

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 24
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	25 - 83
1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	30 - 36
2. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	36 - 40
3. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	40 - 42
4. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	42 - 43
5. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 14 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	43 - 46
6. Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	47 - 61
7. Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	61 - 71
8. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	71 - 76
9. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	76 - 81
10. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	81 - 82
11. Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	82 - 83

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 22-ны өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 30 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, С.Амарсайхан, Ц.Анандбазар, П.Анужин, Ё.Баатарбилэг, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Баярсайхан, Х.Болорчулуун, Ц.Даваасүрэн, Б.Дэлгэрсайхан, Г.Занданшатар, Н.Наранбаатар, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Ц.Туваан, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн, Т.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Ш.Раднаасэд;

Хоцорсон: Ш.Адьяа – 1 цаг 56 минут, Н.Алтанхуяг – 1 цаг 04 минут, Б.Баттөмөр – 11 минут, Д.Ганбат – 32 минут, Г.Ганболд – 57 минут, Б.Жавхлан – 35 минут, Ц.Идэрбат – 2 цаг 06 минут, Л.Энх-Амгалан – 23 минут, Б.Энхбаяр – 31 минут, Ж.Эрдэнэбат – 32 минут.

“Өсвөрийн парламент-2023” хөтөлбөрийн оролцогч хүүхдүүдээс Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүдэд дэвшүүлж буй хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хүүхдийн эрхийг хангах нөхцөл, эрх зүйн орчныг сайжруулах талаарх санал санаачилгыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Туваан, Б.Дэлгэрсайхан нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс мэндчилгээ хүргэв.

Нэг.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “албан ёсны хаяг, байршил бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийг” гэснийг “бүсийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 22
Бүгд: 40
45.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “албан ёсны хаяг, байршил бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийг” гэснийг “бүсийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 6.1.4 дэх заалтын “4.1.7-д” гэснийг “4.1.2-т” гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1.6 дахь заалтын “их өгөгдөл,” гэсний дараа “блокчэйн” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.7 дахь заалтыг 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт болгон өөрчлөх:

“6.1.1.төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40

57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 7.1.1 дэх заалтын “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг, мөн зүйлийн 7.2 дахь хэсгийн “төрөөс” гэснийг, 7.3 дахь хэсгийн “батлахад” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1 дэх хэсгийн “дараах” гэсний өмнө “мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэж нэмж, мөн зүйлийн 8.1.1, 8.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

8.1.2.мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журам, стандартыг боловсруулахад мэргэжлийн холбоотой хамтран ажиллах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг хасаж, мөн зүйлийн 9.1.2 дахь заалтын “гарааны компанийг бойжуулах,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 20

Бүгд: 42

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “хувийн өмчит хуулийн” гэснийг “бусад” гэж, 10.2.2 дахь заалтын “8.1.5-д” гэснийг “8.1.4-т” гэж, 10.2.3 дахь заалтын “8.1.6” гэснийг “8.1.5” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 18

Бүгд: 42

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Х.Ганхуяг нарын гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “орон тооны бус зөвлөл” гэснийг “Үндэсний зөвлөл” гэж өөрчилж, мөн хэсгийн “чиг үүрэг бүхий” гэснийг хасаж, мөн хэсгийн “ажиллана” гэсний дараа “Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.” гэж, мөн зүйлийн 11.5.3 дахь заалтын “ажлын” гэсний өмнө “энэ хуулийн 9.1.8-д заасан” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлж, дэд даргаар Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ажиллана.

11.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засаг, санхүү, төсвийн, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.” Зөвлөлийн бүрэлдэхүүний 50-иас доошгүй хувь нь мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	21
Бүгд:	42

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	19
Бүгд:	42

54.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “орон тооны бус зөвлөл” гэснийг “Үндэсний зөвлөл” гэж өөрчилж, мөн хэсгийн “чиг үүрэг бүхий” гэснийг хасаж, мөн хэсгийн “ажиллана” гэсний дараа “Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.” гэж, мөн зүйлийн 11.5.3 дахь заалтын “ажлын” гэсний өмнө “энэ хуулийн 9.1.8-д заасан” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлж, дэд даргаар Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ажиллана.

11.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засаг, санхүү, төсвийн, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.” Зөвлөлийн бүрэлдэхүүний 50-иас доошгүй хувь нь мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	17
Бүгд:	42

59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын “эхлэлтийн” гэсний өмнө “хуулийн этгээдийн” гэж нэмж, мөн зүйлийн 12.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2.хуулийн этгээдийн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 18

Бүгд: 43

58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Б.Саранчимэг нарын гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3.8 дахь заалтын “бизнес” гэснийг “компанид” гэж өөрчлөн, мөн зүйлийн “13.3.8” гэснийг “13.3.7” гэж, “13.3.9” гэснийг “13.3.8” гэж, “13.3.10” гэснийг “13.3.9” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн “13.3.11” гэсэн заалтыг хасаж, мөн зүйлийн 13.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.4.Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 17

Бүгд: 43

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтын “5.3.10” гэснийг “5.3.18” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 17

Бүгд: 43

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 18

Бүгд: 43

58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хоёр.МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
БУСАД ХУУЛИЙН ТӨСӨЛ**

1.НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	18
Бүгд:	43

58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “5.2¹” гэснийг “5.15” гэж өөрчлөх.

2.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	18
Бүгд:	43

58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	18
Бүгд:	43

58.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “15.1.16” гэснийг “15.1.18” гэж өөрчлөх.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “болон” гэснийг “бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ” гэж өөрчлөх.

3.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	19
Бүгд:	42

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	21
Бүгд:	42

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	19
Бүгд:	42

54.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
/Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбаямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
/Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжүүлэх газрын дарга Б.Ундрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “эсхүл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	23
Бүгд:	43

46.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	18
Бүгд:	42

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Төслийн 2 дугаар зүйлийн “эсхүл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	19
Бүгд:	42

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 2.Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн хуулийн дагаж мөрдөх хугацааг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх, бригадын генерал Д.Баасандамба, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч, хошууч генерал Х.Лхагвасүрэн, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга М.Санжаадорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 14 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны референт Д.Наран-Отгон, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн дарга Б.Баярболд, “Юзисан Партнерс” хуулийн фермийн зөвлөх, хуульч Н.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл хариулж, тайлбар хийв.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 7.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.8.Энэ хуулийн 7.6-д заасан “Ахмадын өргөө”, бусад төв нь төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжид байрлан үйл ажиллагаагаа явуулж байгаа бол барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг гэрээний үндсэн дээр орон нутгийн төсвөөс хэсэгчлэн, эсхүл бүрэн санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	26
Татгалзсан:	18
Бүгд:	44

59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Н.Мөнгөнцэцэг, Хуулийн хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, мөн хорооны гишүүн Д.Ариунтуяа, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ч.Батбямба, П.Хулан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Б.Энх-Амгалан, Н.Учрал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжэе гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Ш.Цолмон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль тогтоомжийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ч.Батбямба, П.Хулан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг хариулж, тайлбар хийв.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Нэг.ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН
ТОМЬЁОЛОЛ**

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 7, 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7, 8, 13, 14 дэх заалт болгох:

7	Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
14	Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40

55.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хоёр.ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**1.ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хуулийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт, Хоёр дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалт, мөн зүйлийн Гурав, Зургаа дахь хэсэгт заасан анхан шатны шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа эрүү, иргэний хэрэг, маргаан, эрүүгийн хэргийн шүүх харьяаллан шийдвэрлэх зөрчлийн хэрэг, маргааныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхэд шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 19

Бүгд: 40

52.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**2.МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ**

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

“32.6.Ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүх болон сэлгэн ажиллах боломжгүй давж заалдах шатны шүүхээс энэ хуулийн 76.2, 95.4-т заасны дагуу шүүгч гишүүнээр сонгогдсон тохиолдолд тухайн шүүгчийн сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлана.

32.7.Энэ хуулийн 32.6-д заасан шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас нэг жилийн дотор сонгон шалгаруулалт зарлахгүй.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 19

Бүгд: 40

52.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “эсхүл тухайн шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан бол адил шатны өөр шүүхэд шилжүүлэн томилуулах хүсэлтээ Ерөнхий зөвлөлд гаргаж болно.” гэснийг “эсхүл тухайн шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад хуульч бүртгүүлээгүй, шалгалтад тэнцээгүй, томилогдоогүй, сэлгэн ажиллах захиалгаар шүүгч хүсэлт ирүүлээгүй, зохист ачааллаас илүү ачаалалтай ажиллаж байгаа нь судалгаагаар тогтоогдсон бол дөрвөөс дээш жил ажилласан шүүгчийн зөвшөөрлийг үндэслэн адил шатны өөр шүүхэд шилжүүлэн томилох саналыг Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид хүргүүлж болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“**2/46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг:**

“46.3.Ерөнхий зөвлөл шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг өөрийн батлагдсан төсвийн хүрээнд тогтоож, нэмэгдэл олгох журмыг батална. Улсын дээд шүүхээс бусад шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хуралд тогтооно.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын 3 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“**1 дүгээр зүйл.**Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Дөрөв. “ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх:

“6/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг эрэн сурвалжлах чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай нэгжийн орон тоо, төсвийг нэмэгдүүлэх, холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжбэ гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Ж.Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	19
Бүгд:	39

51.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Энхсүрэн, “Эрүүл мэнд реформ” төрийн бус байгууллагын гишүүн М.Халиунаа, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн М.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийн “олгох,” гэсний дараа “сунгах, түдгэлзүүлэх, сэргээх,” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “нөлөөт эм” гэсний дараа “, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.2 дахь заалтын “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл гэсэн төрлөөр” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн бүрэлдэхүүн” гэж өөрчилж, 6.1.1 дэх заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 6.1.2 дахь заалтын “/уламжлалт эм/” гэснийг, мөн зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	20
Бүгд:	40

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	17
Бүгд:	39

56.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийн “олгох,” гэсний дараа “сунгах, түдгэлзүүлэх, сэргээх,” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “нөлөөт эм” гэсний дараа “, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.2 дахь заалтын “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл гэсэн төрлөөр” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн бүрэлдэхүүн” гэж өөрчилж, 6.1.1 дэх заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 6.1.2 дахь заалтын “/уламжлалт эм/” гэснийг, мөн зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	17
Бүгд:	39

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 2.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хамт тухайн” гэснийг “хуулийн этгээд” гэж, мөн хэсгийн “нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгоно” гэснийг “нийлүүлж болно” гэж, 7.2.1, 7.2.2 дахь заалтын “сан бүхий энэ хуулийн 6.1.3-т заасан худалдах” гэснийг “сангийн” гэж, мөн заалтын “дүүргийн эмийн сангүй” гэснийг “сангийн хүрэлцээгүй” гэж, 7.2 дахь хэсгийн, 7.5.1, 7.5.2, 7.5.3, 7.5.4 дэх заалтын “олгох, сунгахад” гэснийг “олгоход” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3.1-д,” гэснийг, 7.13 дахь хэсгийн “хууль эрх зүйн хүрээнд” гэснийг тус тус хасаж, 7.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүнээ” гэсний дараа “түүхий эдээ” гэж, 7.11 дэх хэсгийн “саналаар” гэсний дараа “хуралдааны шийдвэр” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.16 дахь хэсэг нэмэх:

“7.16.Энэ хуулийн 7.5.1, 7.5.3, 7.5.4, 19.1, 29.2.4-т заасан зохистой дадлын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	16
Бүгд:	39

59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “энэ хуулийн 7.5-д заасан баримт бичгийг бүрдүүлж,” гэснийг хасаж, мөн хэсгийн “энэ хуулийн 8-11 дүгээр зүйлд заасан үүрэг, шаардлагыг биелүүлсэн байна” гэснийг “Эрүүл мэндийн тухай хуулийн 19.17-д заасныг үндэслэнэ” гэж өөрчилж, мөн зүйлийн 12.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	16
Бүгд:	39

59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.1.Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн хүсэлт, баримт бичиг, түүнд хийсэн шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн уг бүтээгдэхүүнийг бүртгэнэ.

41.6.Энэ хуулийн 41.1-д заасны дагуу бүртгэгдсэн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний жагсаалтыг цахим хуудсанд байршуулж, эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулья.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	17
Бүгд:	39

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 41 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 41.12 дахь хэсэг нэмэх:

“41.12.Энэ хуулийн 41.6-д заасны дагуу бүртгэгдсэн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг иргэн, хуулийн этгээд борлуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.3, 46.9, 46.10 дахь хэсгийн “тусламж, төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 46.10.1 дэх заалтын “шаардлага” гэснийг “стандарт” гэж, 46.10.6 дахь заалтын “эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг” гэснийг “эмийг” гэж тус тус өөрчилж, 46.11 дэх хэсгийн “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг хасаж, мөн хэсгийн “46.10.6” гэсний дараа “46.10.7” гэж нэмж, 46.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.1.Тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авахад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, хандивын эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авахад эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус урьдчилан мэдэгдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалтын “болон орон нутгийн”, “иргэнд үзүүлэх” гэснийг, 47.1.4 дэх заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 47.1.1 дэх заалтын “шаардлагатай” гэснийг “түгээмэл хэрэглэгддэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1.ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 13.17 дахь заалтын “нөлөөт эм,” гэсний дараа “, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж нэмж, 13.18 дахь заалтын “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл гэсэн төрлөөр” гэснийг

“эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж өөрчилж, мөн заалтын 13.17 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 13.17, 13.19 дэх заалтын “гэсэн төрлөөр” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “12.1 дэх заалтын” гэсний дараах ““Эмийн” гэснийг “Эм, эмнэлгийн хэрэгслийн” гэж, мөн заалтын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “13.6” гэсний дараа “; 13.7” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Энхсүрэн, “Эрүүл мэнд реформ” төрийн бус байгууллагын гишүүн

М.Халиунаа, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн М.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	19
Бүгд:	39

51.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг гишүүдийн олонх дэмжсэн тул Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Энхсүрэн, “Эрүүл мэнд реформ” төрийн бус байгууллагын гишүүн М.Халиунаа, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн М.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг гишүүдийн олонх дэмжсэн тул Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 11 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 07 минут үргэлжилж, 72 гишүүнээс 49 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
14 цаг 30 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүдийн амрыг эрье.

Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр 15 асуудал хэлэлцэнэ.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газар өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг хийнэ. Зарчмын зөрүүтэй 20 саналтай.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Ерөнхийлөгч өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг шийднэ.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Ерөнхийлөгч өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлгийг хийнэ. Зарчмын зөрүүтэй 2 саналтай.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын гишүүд өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг хийнэ. Зарчмын зөрүүтэй 1 саналтай.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Хэлэлцэх эсэхийг нь шийднэ.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газрын өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг хийнэ. Зарчмын зөрүүтэй 7 саналтай.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхцал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн

автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

Засгийн газар өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг нь шийднэ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газар өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлгийг хийнэ. Зарчмын зөрүүтэй 11 саналтай.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Үүнийг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан. Анхны хэлэлцүүлэг.

Дараа нь Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт боловсруулсан. Анхны хэлэлцүүлэг хийнэ.

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн нарын гишүүдийн өргөн барьсан хуулийн төсөл байна. Анхны хэлэлцүүлэг хийнэ.

Энэ чинь явж байгаа. Тийм ээ.

Эдгээр асуудлуудыг хэлэлцэнэ. Энэ Малчин өрхийн холбооны хууль Байнгын

хороо хуралдсаны дараа чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын өмнө “Өсвөрийн парламент-2023” хөтөлбөрийн оролцогч хүүхдүүдээс Улсын Их Хурлын гишүүд болон Засгийн газрын гишүүдэд дэвшүүлж буй “Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хүүхдийн эрхийг хангах нөхцөл, эрх зүйн орчныг сайжруулах талаарх санал санаачилга”-ыг Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Х.Булгантуяа танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол орны өнцөг булан бүрд байгаа хүүхэд, залуучуудыг нэгтгэх, тэдний дуу хоолой, оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн зорилгуудыг таниулах, байгаль орчиндоо ээлтэй, хариуцлагатай иргэн болж төлөвшүүлэх зорилготой “Өсвөрийн парламент” хөтөлбөрийг Улсын Их Хурлын Тамгын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай анх санаачлан бид гурав дахь жилдээ хэрэгжүүлээ.

Төрийн болон төрийн бус олон улсын 20 орчим байгууллагуудтай хамтран ажиллаж, үндэсний хэмжээнд бид гурав дахь жилдээ энэ үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, 2024 оны 05 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд бид хаалтын үйл ажиллагаагаа зохион байгуулсан.

Энэ хөтөлбөр ирэх онуудад мөн үргэлжлэн хэрэгжүүлэхээр бид төлөвлөж байна.

2024 оны 05 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд “Өсвөрийн парламент-2023” хөтөлбөрийн хаалтын үйл ажиллагаа нэгдсэн чуулган Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан.

Энэ үеэр хөтөлбөрийн нийт оролцогч хүүхдүүд болон зохион байгуулагч байгууллагууд өмнөх оныхоо гурван жилийнхээ үйл ажиллагааг дүгнэж, цаашид ялангуяа хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн аюулгүй байдал, эрүүл орчинд өсөх, хөгжих боломжийг нэмэгдүүлэх талаар саналаа солилцсон.

“Өсвөрийн парламент” хөтөлбөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн жишиг хөтөлбөрийн нэг болж хаалтын үйл ажиллагаанд Нью-Йорк хотоос Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн баг ирж бидний үйл ажиллагаатай танилцаж, олон улсад сурталчлах ажлыг мөн зохион байгууллаа.

2021, 2022 онуудад хөтөлбөрт жил бүр 900 гаруй хүүхдүүдээс 90 хүүхэд сонгогдож энэ жилээс бид хүүхдийн оролцоог нэмэгдүүлж, 105 орчим оролцогчдыг хамруулснаараа онцлог боллоо.

Нийтдээ гурван жилийн хугацаанд 330 орчим суралцагчид, 21 аймаг, 9 дүүргээс тус хөтөлбөрт оролцсон болно.

Жил ирэх тусам хөтөлбөрт хамрагдахаар хүсэлтээ ирүүлж байгаа хүүхдүүдийн тоо нэмэгдэж байгааг мөн дуулгахад таатай байна.

Оролцогчид нөлөөллийн ажлууд хийх замаар бусдад эергээр нөлөөлж, анги, сургууль, аймаг, дүүрэгтээ бусад олон

хүүхдүүдэд сурсан мэдсэнээ хуваалцаж байдгаараа “Өсвөрийн парламент” хөтөлбөрийн үр дүн, хүрэх нөлөөлөх цар хүрээ өргөн болдог.

Зөвхөн энэ жилд гэхэд 330 оролцогчид маань энэ гурван жилийн хугацаанд гэхэд нөлөөллийн ажил, цахимд лавлагаа ажлуудынхаа хүрээнд 500 гаруй мянган хүүхдүүдэд тогтвортой хөгжлийн зорилго, байгаль орчиндоо ээлтэй байх, хариуцлагатай иргэн байх талаар өөрсдийнхөө сурсан мэдсэнийг хүргэж, хамтран ажиллаж чадсан байна.

Өнгөрсөн хоёр жилд “Уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний хэрэглээ, хэмнэлт”, мөн өнгөрсөн жил “Эрүүл хооллолт, эрүүл ирээдүй” гэдэг сэдвүүдээр бид сургалтуудаа явуулахаас гадна энэ жил “Эрүүл хүүхэд, эрүүл орчин” гэсэн сэдвийн хүрээнд хөтөлбөрөө зохион байгуулсан.

Орчны эрүүл мэндийн асуудал ноцтой тулгарч байгаа энэ үед хүүхдүүд, өсвөр үеийнхний санал бодлыг сонсож, мэдлэг мэдээллийг тэлж, хандлагыг нь төлөвшүүлэх маш чухал байгаа юм.

“Өсвөрийн парламент-2023” хөтөлбөрийн хүрээнд хүрээлэн буй орчны бохирдол, эрүүл мэнд, шийдвэрлэх аргын талаарх өсвөр насныхны мэдлэг хандлагыг тодорхойлох судалгааг Нийслэлийн эрүүл мэндийн Үндэсний төвөөс хийсэн.

Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн зохистой үйлчилгээ нь хүүхдийг эрүүл саруул сурч боловсрох боломжийг ханган, хүүхдийн эрхийг хүндэтгэдэг, сургуулийн орчинд ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж хүртээмжгүй байгаа нь суралцагчдын ирц, сурлагын амжилтад ч гэсэн сөргөөр нөлөөлж байна гэж хүүхдүүд үзсэн байна.

Дээрх судалгааны дүнгээр 10 суралцагч тутмын 6 нь хог хаягдлын менежмент, хог ил задгай хаяж байгаа асуудал энэ нь бүр дадал болж байгаа нь орчны хамгийн их тулгамдсан асуудал байна.

Хог хаягдлын менежментийг сайжруулах талаар төр, засгаас нэлээн хүчтэй арга хэмжээ авах хэрэгтэй байна гэж үзсэн.

Мөн 10 суралцагч тутмын 3 нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй нүхэн жорлонгийн хэрэглээ, нэг удаагийн хуванцар савны хэрэглээ их байна. Үүн дээр анхаарах хэрэгтэй байна гэж хариулсан.

Мөн орон нутагт эдгээр орчны эрүүл мэндийн тулгамдсан асуудал хоттой харьцуулахад их байгаа гэж суралцагчид үзсэн байна.

Орчны бохирдлын гол шалтгаан нь

- **87.7 хувь нь** ил задгай хог хаягдал,
- **75.6 хувь нь** хүмүүсийн буруу дадлаас,
- **60.3 хувь нь** нэг удаагийн хуванцар саваас,
- **49.3 хувь нь** гэр хорооллын нүхэн жорлонгоос

үүдэлтэй байна гэж суралцагсад үзсэн байна.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд Та бүхэнд “**Өсвөрийн парламент-2023**” хөтөлбөрийн оролцогч хүүхдүүд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хүүхдийн эрхийг хангах нөхцөл байдал, эрх зүйн орчныг сайжруулах талаар дараах санал санаачилгыг хүргүүлж байгааг Та бүхэн маань анхаарч, холбогдох Байнгын хороод, холбогдох сайд нар үйл

ажиллагаандаа тусган ажиллахыг хүүхдүүд хүсэж байна.

Хүүхдүүд биднээс орчныг хэрхэн яаж сайжруулах вэ, хүүхдүүдийн зүгээс тулгамдсан асуудал юу байна гэж бид нараас бараг асуудаггүй.

Тэгсэн мөртөө нэг их чухал биш зарим асуудлаар төсөв санхүүг ихээр тавьдаг, бидний оролцоог ерөөсөө хангадаггүй гэдэг дээр нэлээдгүй шүүмжлэлтэй хандсан.

Нэгдүгээрт, Хүүхдийн цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах үүрэг амлалтаа биелүүлэхэд чиглэсэн зоригтой, бодитой алхмуудыг хийж, хүүхдийн эрхийг хүндлэн хамгаалж, ханган биелүүлэх шаардлагатай байна.

Хоёрдугаарт, Бүх насны харилцан адилгүй нөхцөл байдалд байгаа хүүхдүүдэд уур амьсгалын өөрчлөлт өөр өөр нөлөө үзүүлэх магадлалтай учраас хүүхдийн эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээг тогтмол хийдэг баймаар байна.

Хотын хүүхдүүд гэхэд гэр хорооллын хүүхдүүд, мөн хөдөө гэхэд сумын хүүхдүүд, аймгийн төвийн хүүхдүүд гээд энэ уур амьсгалын өөрчлөлт учирч байгаа хохирол, нөлөөлөл харилцан адилгүй байгааг судлах шаардлагатай байна гэж үзсэн.

Гуравдугаарт, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөө, шийдвэр, шийдэл боловсруулахдаа хүүхдүүдийг оролцуулах, хамруулах, мэдээллээр хангах хэрэгтэй байна.

Байгалийн гамшгийн үед ч гэсэндээ хүүхдүүд бидний хувьд хэрхэн яах вэ гэдэг талаар мэдээлэл дутуу дулимаг байдаг нь

хүүхдүүд эрсдэлд орох, осол аваарт орох магадлалыг нэмэгдүүлж байна.

Дөрөвдүгээрт, Хот суурин газарт байрладаг нүүрсээр ажилладаг халаалтын болон уурын зуухыг бүрэн халах. Ялангуяа цэцэрлэг, сургууль, эрүүл мэндийн барилга, байгууламжийг төвлөрсөн системд холбох, эргэн тойронд байгаа мөн барилга, байгууламжийг холбох, цэвэр эрчим хүчний технологи шилжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

XXI зуунд өнөөдөр хүүхдүүд нүүрс түлдэг сургууль, цэцэрлэгт агаар, орчны бохирдол дунд өсөж боловсрох ёсгүй.

Тавдугаарт, Цэцэрлэг, сургуулийн барилгын жишиг зураг төслийг шинэчлэн боловсруулах.

Ялангуяа агаар сэлгэх систем заавал суурилуулах, барилга барихад ашиглагддаг түгээмэл барилгын материалын чанарт хяналт тавих зайлшгүй шаардлагатай байна гэж үзсэн.

Энэ талаар 2022 онд Улсын Их Хурал дээр хяналтын сонсгол явуулсан.

Үүний үр дүнд Замын-Үүдэд барилгын материалын гаалийн лаборатори баригдаж байна.

Мөн энэ онд батлагдсан Хүүхэд хамгааллын хуулиар барилга хүлээн авах комисст хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан хүн тусгайлан ажиллахаар бид тусгаж өгсөн байж байгаа.

Зургадугаарт, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг зэрэг хүүхдийн байгууллагын орчны эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх, үнэлгээний

мэдээллийн сан бий болгох шаардлагатай байна.

Долдугаарт, Сургуулийн барилга, байгууламж, ус дамжуулах шугам хоолой, ус, ариун цэврийн байгууламжийг үер болон байгалийн гамшигт тэсвэртэй байдлаар барьж байгуулах.

Наймдугаарт, Сургууль, цэцэрлэгийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн дэд бүтцийг шинэчлэх, засварлах зардлыг улсын төсөвт үе шаттайгаар тусгах, ялангуяа халуун, хүйтэн усны хэрэглээгээр бүрэн хангах.

Энэ бол нийт сургуулиудын 50 орчим хувь нь л халуун устай байгаа.

Есдүгээрт, Боловсролын ерөнхий хууль танхимын бус сургалтад байгаль орчныг хамгаалах, тандан судлах хүрээнд нийгэмд чиглэсэн ухуулга нөлөөллийн ажлыг нэмж тусгах.

Аравдугаарт, Анги танхимын дүүргэлтийг норм хэмжээнд байлгахад анхаарч ажиллах. Ингэж хүүхдийн өвчлөлтийг бууруулах хэрэгтэй байна.

Арван нэгдүгээрт, Хүүхэд өсвөр үеийнхний байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, дасан зохицох, даван туулах, эрүүл мэндээ хамгаалах чадварыг нэмэгдүүлэх, тэдний санал, санаачилга, үйлдлийг орон нутгийн шийдвэр гаргагчид дэмжих, хамтран хэрэгжүүлэх, үе тэнгийн сургагч, багш нарыг бэлтгэх.

Арван хоёрдугаарт, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын талуудын 29 дүгээр бага хурлыг угтан талуудын 25 дугаар бага хурлаас 2019 онд санаачилж баталсан “Засгийн газар хоорондын

хүүхэд, залуучууд уур амьсгалын үйл хэрэг тунхаг бичиг”-т Монгол Улс нэгдэх.

Арван гуравдугаарт, “Парламентын боловсрол”, “Өсвөрийн парламент” хөтөлбөрүүдээ тасралтгүй сайжруулж, хүүхэд, өсвөр үеийнхэнд бүр илүү хүртээмжтэй, ойлгомжтой, сайн агуулгатай болгох.

Зөвхөн хүүхдүүдээр хязгаарлахгүй ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан сургалтын хөтөлбөр, аргачлалыг сайжруулж, улс даяар энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх.

Арван дөрөвдүгээрт, Парламентын ардчиллын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, иргэд олон нийтэд таниулах, музейтэй байх, түүгээрээ дамжуулан

парламентын түүхээ таниулан сурталчилдаг болох ёстой.

Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчлэлээр энэхүү эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Арван тавдугаарт, Хууль тогтоомж сурталчлах төвийг 21 аймаг, дүүрэгт байгуулан ажиллах зэрэг эдгээр саналуудыг Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод, холбогдох сайд нарт уламжилж өгөөч ээ гээд Өсвөрийн парламент-2023 оны оролцогчид уламжилсныг Та бүхэнд уншиж танилцууллаа.

Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Х.Булгантуяа сайдад баярлалаа.

Хэлэлцэх асуудалдаа орёе.

Нэг.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцье.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулъя.

Таныг индэрт урьж байна.

Ажлын хэсгийг оруулаарай.

Ч.Ундрам: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, орон тооны бус зөвлөлийг Үндэсний зөвлөл болгох, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн тогтмол үйл ажиллагаа явуулах үндэсний зөвлөлийн ажиллах хугацааг хуулийн төсөлд тодорхой тусгах, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлж, зөвлөлийн дэд даргаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байх нь ач холбогдолтой гэж, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаа явуулах байрны түрээсийн зардлын 50 хүртэлх хувийг санхүүжүүлэх гэсэн заалтыг хасах гэсэн саналыг тус тус гаргасан.

Байнгын хорооны гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын нэг бүрчлэн хэлэлцэж, олонхын саналаар дэмжсэн.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх тус Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ч.Ундрам гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Батаагийн Батцэцэг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Сүхээгийн Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Хаш-Эрдэнийн Сүрэнхорол нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураах.

Зарчмын зөрүүтэй 20 санал байна. Гишүүд байраа эзлээрэй. Санал хураах.

Саналын томьёоллоор уншиж танилцуулна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёололыг танилцуулъя.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “албан ёсны хаяг, байршил бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийг” гэснийг “бүсийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтыг хасах:

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн.

Санал хураалт. /алх цохив/ Саналаа өгөөрэй. Санал хураалт явагдаж байна шүү.

Хэн горимын санал гаргах юм? Б.Жаргалмаа гишүүн горимын санал гаргая.

Б.Жаргалмаа: Дарга аа, би сая санал өгөхдөө хоцроод дарчихлаа.

Энэ саналыг хүчингүйд тооцож, дахин санал хурааж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаагийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

57.5 хувийн саналаар Б.Жаргалмаа гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ. Саналыг хүчингүйд тооцлоо. /алх цохив/

Саналын үндсэн томьёололыг уншиж танилцуулсан.

Санал хураалт. /алх цохив/

55.0 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 6.1.4 дэх заалтын “4.1.7-д” гэснийг “4.1.2-т” гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1.6 дахь заалтын “их өгөгдөл,” гэсний дараа “блокчэйн” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.7 дахь заалтыг 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт болгон өөрчлөх:

“6.1.1.төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн.

Санал хураалт. /алх цохив/

57.5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 7 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 7.1.1 дэх заалтын “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг, мөн зүйлийн 7.2 дахь хэсгийн “төрөөс” гэснийг, 7.3 дахь хэсгийн “батлахад” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэж нэмэх:

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн.

Санал хураалт. /алх цохив/

57.5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1 дэх хэсгийн “дараах” гэсний өмнө “мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэж нэмж, мөн зүйлийн 8.1.1, 8.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

8.1.2.мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журам, стандартыг боловсруулахад мэргэжлийн холбоотой хамтран ажиллах;”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн.

Санал хураалт. /алх цохив/

55.0 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар” гэснийг хасаж, мөн зүйлийн 9.1.2 дахь заалтын “гарааны компанийг бойжуулах,” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн.

Санал хураалт. /алх цохив/

52.4 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “хувийн өмчит хуулийн” гэснийг “бусад” гэж, 10.2.2 дахь заалтын “8.1.5-д” гэснийг “8.1.4-т” гэж, 10.2.3 дахь заалтын “8.1.6” гэснийг “8.1.5” гэж тус тус өөрчлөх:

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар.

Санал хураалт. /алх цохив/

57.1 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “орон тооны бус зөвлөл” гэснийг “Үндэсний зөвлөл” гэж өөрчилж, мөн хэсгийн “чиг үүрэг бүхий” гэснийг хасаж, мөн хэсгийн “ажиллана” гэсний дараа “Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.” гэж, мөн зүйлийн 11.5.3 дахь заалтын “ажлын” гэсний өмнө “энэ хуулийн 9.1.8-д заасан” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлж, дэд даргаар Цахим хөгжил, харилцаа холбооны асуудлаар эрхэлсэн Засгийн газрын гишүүн ажиллана.

11.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засаг, санхүү, төсвийн, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.”. Зөвлөлийн бүрэлдэхүүний 50-иас доошгүй хувь нь мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл байна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Х.Ганхуяг.

Санал хураалт. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүн
Т.Аубакир горимын санал гаргая.

Т.Аубакир: Сая дэмжиж санал
өгсөн боловч энэ ажилласангүй.

Хүчингүй болгоод, дахин санал
хураалт явуулж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын
гишүүн Т.Аубакирын гаргасан горимын
саналаар уг санал хураалтыг хүчингүйд
тооцох санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

54.8 хувиар санал дэмжигдлээ.

Т.Аубакир гишүүний гаргасан
саналаар санал хураалт хүчингүйд
тооцогдлоо.

Үндсэн санал хураалтын саналын
томьёоллыг уншиж танилцуулсан.

Санал хураалт. /алх цохив/

59.5 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.3
дахь заалтын “эхлэлтийн” гэсний өмнө
“хуулийн этгээдийн” гэж нэмж, мөн
зүйлийн 12.1.2 дахь заалтыг доор
дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2.хуулийн этгээдийн
ажилтны нийгмийн даатгалын шимтгэл
төлөлтийн талаарх тодорхойлолт”

Санал гаргасан Улсын Их Хурлын
гишүүн Энхбаярын Батшугар.

Санал хураалт. /алх цохив/

58.1 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3.8
дахь заалтын “бизнес” гэснийг
“компани”д гэж өөрчлөн, мөн зүйлийн
“13.3.8” гэснийг “13.3.7” гэж, “13.3.9”
гэснийг “13.3.8” гэж, “13.3.10” гэснийг
“13.3.9” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн
“13.3.11” гэсэн заалтыг хасаж, мөн зүйлийн
13.4 дэх хэсгийг доор дурдсаар өөрчлөн
найруулах:

“13.4.Энэ хуулийн 13.2, 13.3-д
заасан татварын болон татварын бус
дэмжлэг үзүүлэх журам бус дэмжлэг
үзүүлэх журмыг Засгийн газар батална.”

Санал гаргасан Улсын Их Хурлын
гишүүн Энхбаярын Батшугар, Батсүхийн
Саранчимэг.

Санал хураалт. /алх цохив/

60.5 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.4
дэх заалтын “5.3.10” гэснийг “5.3.18” гэж
өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын
гишүүн Энхбаярын Батшугар.

Санал хураалт. /алх цохив/

60.5 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн талаарх зарчмын
зөрүүтэй саналын томьёолол
дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн
бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс
дараалал, зүйл заалтын дугаар, ишлэлийг
нийцүүлэн өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын
гишүүн Энхбаярын Батшугар.

Санал хураалт. /алх цохив/

58.1 хувиар санал дэмжигдлээ.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёололыг танилцуулъя.

Нэг.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлгийг явуулъя.

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар. /алх цохив/

58.1 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “5.2¹” гэснийг “5.15 гэж” өөрчлөх.

2.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар. /алх цохив/

58.1 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар.

Санал хураалт. /алх цохив/

58.1 хувиар санал дэмжигдлээ.

Дөрөв. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “15.1.16” гэснийг “15.1.18” гэж өөрчлөх.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “болон” гэснийг “бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ” гэж өөрчлөх.

3.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар.

Санал хураалт. /алх цохив/

54.8 хувиар санал дэмжигдлээ.

Тав.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар.

Санал хураалт. /алх цохив/

Уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалтыг явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

54.8 хувиар санал дэмжигдлээ.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

54.8 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүллээ. Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийнхаа асуудалд орно.

Хоёр.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
/Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар танилцуулна.

Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулъя.

Я.Содбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн.

Мөн зүйлийн 2 дугаар хэсэгт төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.

30 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн

тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн гэж заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт эрхэмлэн хамгаалах үндэсний эв нэгдлийн зорилгын хүрээнд ард түмнийхээ эв нэгдлийг бэхжүүлэх зорилт, арга хэмжээнүүдийг тодорхой тусгасан байдаг.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиар Монгол Улсын төрийн сүлд, туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэглэх журмыг хуульчлан зохицуулж байгаа бөгөөд уг хуулийн 13 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт төрийн далбааг байнга мандуулах газрыг тодорхойлж, мөн хуулийн 25 дугаар зүйлд иргэд, өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн бэлгэ тэмдгийг гүнээ дээдлэн хүндэтгэж, бүх ард түмний баяр наадам, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ болон бусад үед төрийн сүлд, далбаагаа барих, байрлуулах, мандуулах болон буюу төрийн дуулгыг эгшиглүүлж болохоор заасан.

Төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандах, түүхт ёс, түүхэн уламжлалаа нандигнан өвлөх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг байнга мандуулах эрх зүйн орчныг сайжруулах, түүнчлэн төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд дурсгал болгон хадгалуулах зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх зорилгоор Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд Төрийн далбааг байнга мандуулах газар байршлыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтоож байхаар, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд улс орноо сурталчлах эх оронч үзлийг төлөвшүүлэх

зорилгоор төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд хүндэтгэлтэйгээр гардуулан өгөх тус тус эрх зүйн зохицуулалтуудыг шинээр тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийн илэрхийлэл болсон төрийн бэлгэ тэмдэг төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандах, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан журмын дагуу Засгийн газарт хүргүүлж санал авсан бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурдагдсан асуудлуудыг хүлээн авч төсөлд тусгалаа.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Я.Содбаатар даргад баярлалаа.

Санал хураалт явагдана. Гишүүд байраа эзлээрэй.

Байнгын хорооны санал, дүгнэлт одоо уншигдана.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна.

Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандах, түүхт ёс, түүхэн уламжлалаа нандигнан өвлөх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг байнга мандуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, түүнчлэн төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд дурсгал болгон хадгалуулах зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх зорилгоор Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийн илэрхийлэл болсон төрийн бэлгэ тэмдэг төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандах, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзжээ.

Дээрх хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын D-Parliament.mn цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа төрийн далбааг байнга мандуулах байршлийг хэрхэн тогтоох талаар асуулт асууж хариулт авсан болно.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.2 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Д.Сарангэрэл гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Рагчаагийн Батрагчаа нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

С.Ганбаатар гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар асуултаа асууя.

С.Ганбаатар: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Зарчмын хувьд.

Зүгээр асуух, тодруулах нэг зүйл байна. Юу гэвэл төрийн сүлд, төрийн далбаа, төрийн дуулал гэхийг.

Я.Содбаатар дарга аа,

Улсын гэдгээр яагаад сольж болдоггүй юм бэ? Энэ ер нь онолын хувьд би бодож явдаг зүйл л дээ.

Монгол Улсын сүлд, Монгол Улсын далбаа, Монгол Улсын дуулал гэж байдаг гэж байх ёстой болов уу.

Улс мөнх орших уу, ер нь төр мөнх орших уу?

Манай сонгууль болгоноор л үүнийг өөрчилж ингэж янз бүр болдог. Миний бодлоор “Дархан манай тусгаар улс Даяар Монголын ариун голомт” гэж дуун дээрээ хүртэл “улс” гэж байгаа шүү.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай энэ асуудал дээр мэргэжилтнүүдийн, шинжээчдийн судалсан барьсан зүйлүүд байгаа юу? Миний энэ асуултад хариулж өгөөч ээ.

Л.Мөнхбаатар: С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар хариулъя. 3 дугаар микрофоныг өгье.

Я.Содбаатар: Хоёр зүйл хэлэх гэсэн юм.

Нэг дэх нь, С.Ганбаатар гишүүний ярьж байгаа зүйл ер нь нэлээн олон жил яригдаж байгаа.

Тэгээд Үндсэн хуулийн асуудал парламентын асуудал учраас парламент

Үндсэн хууль дээр тодорхой зааж өгсөн байдаг.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн.

Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ гээд.

Тэгэхээр энэ хэллэг, энэ нэршил өөрөө Үндсэн хуульд заасан энэ юугаараа явж байгаа гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрт, ер нь энэ хуулийг гаргаж байгаа асуудал нь ер нь цаашдаа бид энэ төрийнхөө далбааг ялангуяа хаана байнга байрлуулж байх вэ, энэ далбааны байнга мандуулах байршил юуг тодорхой болгоё.

Тэгээд энэ жил бид чадвал 07 сарын 10-ны өдөр “Төрийн далбааны өдөр” гэж байдаг. Энэ өдрөөр 60 метр өндөр төрийн далбааг Монгол Улс мандуулах гэж байгаа юм. 60 метр өндөр.

Тэгээд Америкийн Нэгдсэн Улс, Турк, Киргиз гээд маш олон орнуудад төрийн далбаагаа байнга мандуулдаг. Энэ нь өөрөө залуучуудад эх орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд их нөлөө үзүүлдэг. Улсаараа бахархах, ард түмнээрээ бахархах, эх орноороо бахархах ийм үзэлд их нөлөө үзүүлдэг юм байна гэж олон улсад ч гэсэн үздэг.

Тийм учраас улс орнууд бүгд л ингэж мандуулдаг.

Манай улс ч гэсэн өнөөдөр төрийн ёслолын арга хэмжээ, гадаад зочин, төлөөлөгчдийн арга хэмжээ, тэмдэглэлт болон нийтээрээ тэмдэглэх өдрүүдэд л бид

Сүхбаатарын талбай дээр төрийн далбаагаа мандуулдаг.

Үүнийгээ бид байнга мандуулдаг тийм 60 метр өндөр төрийн далбааг хийж байгаа.

Энэ бүтээн байгуулалтын ажлыг бид 07 сарын 10-нд нээх гэж байгаа.

Тэгээд үүнтэй холбогдуулаад цаашдаа энэ төрийн далбааг байрлуулах байршил, үүнийг мандуулахтай холбоотой журмыг Ерөнхийлөгч яаж байхаар л хуулийн төслийн өөрчлөлт орж ирж байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Уг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Санал хураалт явуулья. Гишүүд байраа эзлээрэй.

Байнгын хорооны саналаар Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Гишүүд суугаарай.

Санал хураалт. /алх цохив/

54.8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалдаа орно.

**Гурав.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай
хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**
/Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эрхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулья.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна.

Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн

хуралдаанаараа Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт санал гаргаагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужингаас хуулийн төслийн 2 дугаар зүйлийн “эсхүл” гэснийг хасах, төслийн 3 дугаар зүйлийн хуулийн хэрэгжих хугацааг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх талаар зарчмын зөрүүтэй 2 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллийг Та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: М.Оюунчимэг гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Рагчаагийн Батрагчаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Сархадын Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжүүлэх газрын дарга Болдын Ундрал нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураая. Зарчмын зөрүүтэй 2 санал байна.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёололыг танилцуулъя.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “эсхүл” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Анужин.

Санал хураалт. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн горимын санал гаргая.

Д.Тогтохсүрэн: Би сая санал дэмжиж өгсөн боловч миний санал эсрэг гарсан юм байна.

Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ. Байраа эзлээрэй.

57.1 хувиар санал дэмж дэмжигдлээ.

Тийм. Хүчингүйд тооцсон. Тийм ээ. Одоо үндсэн санал хураалтаа явуулчихъя.

Санал хураалт. /алх цохив/

54.8 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн Санал хураалт.

2.Төслийн 3 дугаар зүйлийн хуулийн дагаж мөрдөх хугацааг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужин.

Санал хураалт. /алх цохив/

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийнхаа асуудалд орно.

Дөрөв.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулъя.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны журмын дагуу хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир албан үүргээ гүйцэтгэж байгаад амь насаа алдсанаас гадна эрүүл мэндээрээ хохирсон, хөдөлмөрийн төрийн чадвараа алдсан албан хаагчдын асуудлыг хэрхэн зохицуулах талаар одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар төрийн цэргийн байгууллагуудаас үзүүлж байгаа дэмжлэг тусалцааны талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: М.Оюунчимэг гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Рагчаагийн Батрагчаа, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх бригадын генерал Дашцэдэнгийн Баасандамба, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч, хошууч генерал Хожгорын Лхагвасүрэн, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Гомбожавын Ариунбуян, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга Мижиддоржийн Санжаадорж нар оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ. Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудал орёё.

Тав.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 14 гишүүн
2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Ш.Адъяаа, Х.Баделхан, Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Б.Бейсен, Г.Дамдинням, Гомпилдоогийн Мөнхцэцэг, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж, Н.Учрал, Ц.Цэрэнпунцаг нараас 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, санал гаргаагүй болно.

Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан зарчмын зөрүүтэй нэг саналаар санал хураалт явуулж, Байнгын хорооны хуралдаанд

оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Д.Сарангэрэл гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Амарсайханы Хишигбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг

зохицуулах газрын дарга Болдын Ундрал, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга Сандагийн Тунгалагтамир, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны референт Дамбаагийн Наран-Отгон, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Сэмбэрдоржийн Жаргалсайхан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн дарга Бүдрагчаагийн Баярболд, “Юзисан Партнерс” хуулийн фермийн зөвлөх, хуульч Нэргүйн Энхбат нар оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

С.Ганбаатар гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар асуултаа асууя.

С.Ганбаатар: Би нэг тодруулах зүйл байна.

Юу гэвэл энэ төслийн 1 дүгээр зүйлийн 6.9 дүгээр зүйлийн 9.9-өөс 9.13 дахь хэсэгт хуудас 3-д байгаа шүү. Би тэрийг тодруулж асууя.

Энэ дээр ингэж заасан байна. 9-ийн 9-д шимтгэл 8.5 хувийг нийгмийн даатгалын санд төлөхгүй гэж бичсэн байж байгаа. Хуудас 3-ыг би ярьж байна шүү.

Үүнийг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.3.4, 7.6-д нэгэнт зохицуулсан гэж би үзэж байгаа.

Хуулийн түүврийн хуудас нэгд нь энэ дээр бүр тодорхой бичсэн байгаа. Үүнийг яаж шийдсэн бэ?

Төрийн албаны тухай хуульд төслөөр 27.4 гэсэн шинэ заалт нэмнэ. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хуудас 13-ыг үзнэ үү. Засгийн газрын тэмдэглэлийн 14-д төслийг дэмжихгүй гээд бичсэн байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсгийн төслөөс хасах гэсэн санал бүр өгсөн байгаа шүү.

Үүнийг би тодруулж асууя. Энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ? Хуулийн түүврийн хуудас 1-ээс 2-ыг л би яриад байгаа юм шүү. Би асуултаа асуулаа.

Л.Мөнхбаатар: С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Ажлын хэсгийн ахлагч Даваажанцангийн Сарангэрэл хариулъя. Д.Сарангэрэл гишүүний микрофоныг өгөөрэй.

Д.Сарангэрэл: Баярлалаа. С.Ганбаатар гишүүн маань чухал асуудал хөндөж байна.

Энэ хуулиар бид Ахмадын хөдөлмөр эрхлэлтийн тусгай бүлэг оруулж өгсөн байгаа.

Тэгээд тэтгэвэртээ гарсан ч гэсэн өөрийнхөө мэдлэг, туршлагаа залуучуудад өвлүүлэх ийм чадварлаг ахмадууд маань төрийн болон хувийн байгууллагуудад ажиллах боломжийг энэ хуулиар нээж өгч байгаа.

Ингэхдээ тухайн ахмад маань ажиллах хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүйгээр цалингаа бүтнээр нь

авах боломж нь өөрийнх нь хүслээс хамаарах байгаа юм.

Цэргийн албанд ажил алба хашиж байгаад залуудаа тэтгэвэртээ гардаг. Тийм хүмүүс үргэлжлүүлээд нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх сонирхолтой байдаг.

Тэгэхээр тэдгээр хүмүүс төлж болно. Тэтгэвэрт гарах эрх нь нээгдээд тэтгэвэртээ гарчихсан хүмүүс хөдөлмөр эрхлэх юм бол тэр нийгмийн даатгалын шимтгэл төлөх нь өөрөө тухайн хүний хүсэл эрмэлзлээс хамаарна гэдэг ийм сонголттой заалтыг оруулж өгсөн юм байгаа юм.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу? С.Ганбаатар гишүүн ээ. Ойлголоо.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураа. Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Нэг санал байгаа.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал байгаа юм байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 7.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.8.Энэ хуулийн 7.6-д заасан “Ахмадын өргөө”, бусад төв нь төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжид байрлан үйл ажиллагаагаа явуулж байгаа бол барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг гэрээний үндсэн дээр орон нутгийн төсвөөс хэсэгчлэн, эсхүл бүрэн санхүүжүүлнэ.”

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

59.1 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

Ажлын хэсэгт баярлалаа. Их чухал хууль батлагдлаа шүү.

Санаачилсан Нямаагийн Энхболд гишүүн, ажлын хэсгийг ахалж ажилласан Даваажанцангийн Сарангэрэл нарын гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё.

**Зургаа.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн
2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна.

Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулаарай.

Мэндчилгээ уншиж танилцуулъя.

Төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбатад мэндчилгээ хүргэе.

Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат нь 05 дугаар сарын 22-нд төрсөн байна.

Аав Паламын Дашдондог, ээж Цэрэн, 6 хүүхэдтэй айлын 3 дахь хүүхэд болон төрсөн байна.

Ингээд Улсын Их Хурлын эрхэм гишүүн Дашдондогийн Ганбат танд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, Монголын ард түмний элч болсон Танд болон танай гэр бүлийнхэнд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Мөн 05 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан, 05 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан нар мөн мэндэлсэн байна.

Эдгээр гишүүдэд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ ард түмний элч болсон Та бүхэнд гэр бүлийнхэнд нь Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Хэлэлцэх асуудалдаа орно.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Д.Цогтбаатар: Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан **“Алсын хараа-2050”** Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “2021-2030 онд хэрэгжүүлэх эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана” гэсэн зорилтын хүрээнд

- шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө;

- ухаалаг засаглалын чиглэлд шүүх үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгоно;
- ёс зүйн цогц чадамжтай шүүхийн хүний нөөц бэлтгэх суурь тогтолцоог бий болгож төгөлдөржүүлнэ;
- шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж, шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгон, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлнэ

гэж шүүх эрх мэдлийн салбар дахь ил тод, нээлттэй байдал, цахимжилтын хөгжлийг тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай хуулиудыг баталснаар төрийн аливаа байгууллага нээлттэй, ил тод байдлыг хангах, хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цахим засгийг бэхжүүлэх эрх зүйн орчинд ахиц гарсан.

Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх, цахимжилтыг нэвтрүүлэхэд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагатай тул Монгол Улсын шүүхийн тухай хуульд шүүхийн нээлттэй, ил тод байдлыг сайжруулах, шүүхийн үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй байдлыг дээшлүүлэхэд цахимжилтыг эрчимтэй нэвтрүүлэх, цахимжсан шүүхийн орчинд шүүхийн

хүний нөөцийн оновчтой, зохистой удирдлагаар хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор Монгол Улсын шүүхийн тухай хуульд болон түүнд холбогдуулан Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Төрийн албаны тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсрууллаа.

Нэг. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйл Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх асуудлыг зохицуулсан бөгөөд энэ зүйлийг өөрчлөн найруулах замаар шүүх нээлттэй ил тод байх арга зам буюу хэлбэрийг нарийвчлан зохицууллаа.

Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэрийг сонирхогч этгээд биечлэн болон цахимаар танилцах боломж бүрдэнэ.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр хуулийн хүрээнд шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуу, дүрсний бичлэгээр хүргэх харилцааг тухайлан тусгалаа.

Ингэхдээ нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг шүүхийн цахим хуудаст, эсхүл шүүхийн нээлттэй бусад цахим платформд заавал байршуулж олон нийт бодит мэдээллийг цаг тухайд нь шуурхай авах боломжоор хангагдана.

Хоёр.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хууль цахимжилттай холбогдуулан дараах өөрчлөлтийг тусгалаа.

Эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах бөгөөд ажиллагааны бэлтгэл хангах үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор захиргааны хэргийг шүүхэд цахимаар хянан шийдвэрлэх ажиллагааг 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс, эрүү, иргэний хэргийн хувьд 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэхээр тусгалаа.

Цахимаар хэрэг хянан шийдвэрлэхэд цахим платформыг ашиглах бөгөөд тухайн платформын онцлогт тавигдах шаардлагын талаар зохицуулсан.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь цахимаар харилцахад төрийн байгууллагын албаны цахим шуудан, иргэний **e-mongolia** өргөтгөлтэй цахим шуудан, Монголын өмгөөлөгчдийн холбооны цахим системд холбогдсон **“цахим шуудан”**, хуулийн этгээдийн таньж баталгаажуулах тохиргоо бүхий цахим шууданг ашиглана.

Цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчтэй харилцах, нотлох баримтыг хүлээн авах, үнэлэх, шүүх хуралдааныг явуулах, шийдвэрийг хүргүүлэх зэрэг шүүн таслах бүх ажиллагаанд хамаарна.

Гурав.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн эрх зүйн байдал, тогтолцоог гадаад улсуудын ижил чиг үүрэг, түвшний шүүхийн сургалтын байгууллагын тогтолцоонд нийцүүлэн **“Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи”** байхаар тусгасан.

Шүүхэд цахимжилт нэвтэрч, шүүхийн захиргааны хүний нөөцийг шуурхай удирдах уян хатан зохицуулалтаар хангахад шүүхийн захиргааны байгууллага хүний нөөцийн бодлого бие даан хэрэгжүүлэх шинэлэг заалтууд Монгол Улсын шүүхийн тухай хуульд тусгагдсан байгаа.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76.2, 95.4-д зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний 5-ыг, Шүүхийн сахилгын хорооны гишүүний 5-ыг шүүгчид дотроосоо сонгодог болсноор шүүгч нь сонгогдон өөр ажил эрхэлж буй тухайн шүүхүүдэд мөн тооны орон тоо дутагдаж, шүүн таслах ажиллагаанд ачаалал үүсэж, шүүхийн үйлчилгээний шуурхай байдал хөндөгдөж байна.

Шүүгч ийнхүү хуульд заасны дагуу өөр ажилд тодорхой хугацаагаар томилогдон ажиллах тохиолдолд тухайн анхан, давж давж заалдах шатны шүүхэд мөн тооны орон тоо нэмэх замаар шүүхийн ачааллыг тэнцвэржүүлж, шүүхийн үйлчилгээний шуурхай байдлыг хангахаар зохицууллаа.

Тав.Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3-д тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан

хугацааны, цол, зэрэг дэвийн докторын, мэргэжлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс бүрдэхээр заасан бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хууль шүүгчийн зэрэг дэвийн асуудлыг зохицуулаагүй орхигдуулсан тул шүүгчийн зэрэг дэвийн асуудлыг Монгол Улсын Их Хурал хуульд нийцүүлэн нарийвчлан тогтоохоор төсөлд тусгалаа.

Зургаа. Шүүгчийн туслахын албан тушаалд эрх зүйч ажиллах боломжтой байсныг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуульч ажиллагаар хуульчилсан нь бүх шатны шүүхэд шүүгчийн туслахын хомсдол бий болох шалтгааны нэг болсон.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсгийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байх шаардлагыг хасах нь нэн яаралтай зайлшгүй шийдэх асуудал болоод байгаа тул энэхүү заалтад өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулаа.

Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Д.Цогтбаатар гишүүнд баярлалаа.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Н.Учрал, Д.Цогтбаатар нарын гишүүд 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч хуулийн төслийг боловсруулахдаа шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх, цахимжилтыг нэвтрүүлэх, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагын үүднээс хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэрийг сонирхогч этгээд биечлэн болон цахимаар танилцах боломж бүрдүүлэх, шүүх хуралдаан нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуу, дүрсний бичлэгээр хүргэх, нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг шүүхийн цахим хуудаст, эсхүл шүүхийн нээлттэй бусад цахим платформд байршуулах, цахим ямар ч тохиолдолд авлигалын гэмт хэрэг хянан шийдвэрлэх, шүүх хуралдааныг нээлттэй хийх, шүүхэд цахим архив, систем, платформыг хөгжүүлэх зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нэмэлт чиг үүргийг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон бусад материаллаг

зардалд жилд ойролцоогоор 1 тэрбум 852 сая 208 мянган төгрөг зарцуулсан шаардлагатай гэж үзсэн бөгөөд хуулийн төслийг **D-Parliament.mn** цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг хуулийн төслийн гол үзэл баримтлалын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир шүүхийн тухай хуулийг шинэчлэн батлаад гурван жилийн хугацаа өнгөрч байгаа бөгөөд уг хуулийн амин сүнс болох шүүхийн ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэхэд тулгараад байгаа асуудлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан шүүх хуралдааны дуу, дүрсний бичлэг, тэмдэглэлийг эвлүүлэн өөрчлөлт хийх, засвар оруулахаас урьдчилан сэргийлэх зохицуулалтын талаар, шүүхийн цахим хуудас байршуулах мэдээллийн хугацааны талаар хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авсан болно.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан

- Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төслийн ач холбогдлын талаар, шүүхийн ил тод нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэхийн тулд холбогдох бусад хууль тогтоомжийг уялдуулан боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагын талаар, мөн цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулах эрхийн талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангахад шүүх нь өөрсдийн бие даасан мэргэжлийн

хэвлэл мэдээллийн сувагтай болох нь зүйтэй талаар, ганц Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бус холбогдох бусад нууцтай холбоотой хууль тогтоомжийг уялдуулан засаж сайжруулах талаар,

- Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүгийн асуудлыг анхаарах нь зүйтэй талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан өмгөөлөгч болон хэргийн талууд хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагааны явцад холбогдох хавтаст хэрэгт авагдсан материалтай танилцах, хэвлэн авах эрхийг нээж өгөх талаар, материалыг өмгөөлөгч болон хэргийн оролцогчдод өгөхдөө эх хувийг өөрчилж хасахгүйгээр хүлээлгэн өгөх баталгаа хангах талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин шүүхийн ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ бусад хууль тогтоомжоор зохицуулсан аливаа нууцтай холбоотой асуудлыг цэгцлэх цаг нь болсон талаар тус тус үг хэллээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд
ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ц.Мөнхцэцэг гишүүнд баярлалаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Д.Ганбат гишүүн, Б.Баттөмөр гишүүнээр тасаллаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат асуултаа асууя.

Д.Ганбат: Өнөөдөр гадаа сайхан шиврээ бороотой их сайхан зуны сайхан өдөр болж байна. Тийм.

Тэгээд бас миний төрсөн өдөрт Улсын Их Хурлаас баяр хүргэсэнд их талархалтай хандаж байна.

Өнөөдөр олон сайхан хуулиуд батлагдаж байна. Ард түмэндээ зориулагдаад. Тухайлбал, одонтой ээжүүдийн, цэргийн албан хаагчдын, мөн ахмад настнуудын талаар нааштай сайхан шийдвэрүүд гаргаж байгаад.

Дандаа л би олонхыг шүүмжилж байдаг хүн.

Энэ тал дээр манай олонх сайн ажиллаж байна гэдгийг тэмдэглэе.

Угаасаа тэгээд халамжийн талаасаа, социалист талаасаа сайн ажиллаж байх ёстой шүү дээ. Тэр талдаа гайгүй үлдсэн хуулиудаа ингээд баталчихлаа.

Энэ бүх үүрэг даалгавар бид нарын нуруундаа ирнэ. Сонгуулийн дараа.

Бид яах вэ баялаг бүтээгчдээ дэмжээд тэгээд энэ хуулиудыг аль болохоор биелүүлэх энэ тал дээр манай Ардчилсэн нам ажиллана гэдэгт та нар эргэлзэхгүй байж болно.

Ингээд шүүхийн талаар ил тод байх энэ хуулиа ярьж байна.

Тэгээд энэ бол би хоёр талтай гэж үзэж байгаа. Сайн тал байна. Нөгөө талаар энэ олон нийтийн сүлжээ их хөгжчихсөн. Мэдээллийг хэн дуртай хүн нь тавьдаг. Хүмүүсийг тархи толгой, сэтгэл санааг нь бэлддэг. Энэ тал руу нь

хандуулаад нөгөө шүүгдэгчийг яллах ч юм уу, ийм маягтай тал руу нь оруулахад нөлөө байх уу, байхгүй юу? Сайн талууд нь ямар талууд байна? Муу талууд нь ямар тал байна? Энэ юмыг Та бүхэн Улсын Дээд шүүхээс саналыг нь авсан уу? Энэ талаар Засгийн газраас саналыг нь авсан уу? Энэ талаар ямаршуухан дүгнэлт гарсан юм бэ? Үүнийг тодруулъя.

Шүүхийн хараат бус байх, шүүгчид ч нөлөөлөхгүй байх, шүүхийн шийдвэр хуулийн дагуу гарах энэ бүх юм чинь бас зарим талдаа нэг тал руугаа туйлширсан, тухай олон нийтийн гадна үзэмжээр нөгөө шүүгч рүү шахалт үзүүлсэн ийм л зүйл болох юм биш биз?

Бусад улс орнуудад ямар байдаг юм бэ? Үүнийгээ судалж харсан уу гэдгийг тодруулъя.

Л.Мөнхбаатар: Төрсөн өдөр нь болж байгаа Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Хууль зүйн байнгын хороон дарга Дамдины Цогтбаатар хариулъя.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүндээ төрсөн өдрийн мэнд хүргэе.

Тэгээд энэ яг өөрийн чинь асууж байгаа энэ болгоомжлолууд зөв өө. Яг энэ болгоомжлолуудыг чинь шийдэх гэж үүнийг оруулж ирж байгаа юм.

Яагаад гэвэл шүүх нээлттэй гэдэг тунхаг зарчимтай. Яг амьдрал дээрээ хаалттай байгаад байгаа учраас энэ чинь харин нөгөө олон нийтэд тэгэхээр тэр мэдээлэлгүй болохоороо өөрсдийнхөө дүгнэлтийг гаргаад тэгээд ёстой таны хэлж байгаагаар аль хэдийн хэн нэгнийг нь буруутгаад, харлуулаад. Тэгсэн шүүх

дээр яг бодитоор ямар материалууд хэлэлцэгдээд байгаа юм, нотлох баримтууд нь юу байгаа юм.

Үүнийг нь ингээд дүгнэж байгааг олон түмэн мэдэхгүй болохоор ёстой гэмгүй хүнийг баахан харлуулчихсаны дараа хүмүүс тэгж бодоод, өөр дүгнэлт гараад байж магадгүй.

Олон нийт ингээд бодчихсон байхад шүүх хуралдаан хэрэв хаалттай явчих юм бол шүүгч шийдвэрээ гаргахдаа яана аа, би олон нийттэй нийцүүлж шийдвэр гаргахгүй бол болохгүй болчихлоо гээд нөгөө хаалттай бичиг баримтууд нь нууц байгаа хуралдааны чинь дараа шүүгч нь угаасаа тэр материалуудаа тайлбарлаж чадахгүй ийм байдал үүсэх гээд байгаа юм.

Тийм учраас шударга нь ерөөсөө л нээлттэй байх. Яагаад гэвэл Монгол Улсын өнөөдөр хуулийн дагуу, шүүхийн хуулийн дагуу энэ чинь нээлттэй байх ёстой зарчимтай байхгүй юу.

Амьдрал дээрээ хэрэгжээд ирэхээрээ процессын хуулиудаар хаагаад хаагаад хаячихдаг. Хаахдаа нэг жижигхэн албан тушаал хаа нэгтээ нууц гэдэг тамга дарчихсаны дараа Монгол Улсын бүх процесс дээр энэ нь хаагдаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг ерөөсөө нээлттэй болгох нь хамгийн зүйд нийцсэн. Тэгээд энэ бол Монгол Улсын өөрийнх нь хууль. Үүнийг харин хэрэгжүүлэх үүд хаалгыг нээж байгаа юм.

Тэгээд бусад оронд ч гэсэн бүгдээрээ. Одоо жишээлбэл Америкт бүхэл бүтэн шүүхийн суваг байгаад шүүх хуралдааныг шууд ил тод, нээлттэй явдаг шүү дээ.

Тэгэхээр яг тэр зарчмаар явуулахыг бид зорьж байгаа юм.

Тэгээд засаг дэмжсэн. Засгаас яг ном журмаараа энэ дээр саналыг нь авсан. Дээд шүүх хамгийн түрүүн энэ саналаа өөрсдөө гаргаж. Би очиж юу завсарлагын үеэр уулзахад.

Тэгээд энэ дээр нь би тэгвэл бид дэмжээд өгье өө гээд санаачилга гаргаад тэгээд Дээд шүүхтэй ярьж байгаад тэдний саналуудыг бүгдийг нь тусгаад оруулж ирж байгаа ийм хууль байгаа юм.

Л.Мөнхбаатар: Одоо Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.

Б.Баттөмөр: Шүүх байгуулах тухай, Шүүхийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж байна.

Энэ маш чухал л асуудал хэлэлцэж байна л даа.

Монгол Улсын энэ авлигалын индекс 121-д ороод 5 байраар ухарчихсан байгаа. Энд одоо энэ шүүхийн ил тод бус байдал гээд нөлөөлсөн нөлөөллүүд байдаг. Тийм.

Тэгэхээр зэрэг энэ хуулиудад ингэж өөрчлөлт оруулахдаа хэлэлцүүлэг хэр зэрэг хийгдсэн бэ?

Нэгдүгээрт, хэлэлцүүлэг хэр зэрэг хийгдсэн бэ? Иргэдийн саналыг авсан уу? Олон нийтийн байгууллагуудын саналыг авсан уу?

Шүүхийн практик гэдэг нэг ойлголт байдаг. Тийм ээ. Энэ дээр харьцуулалт хийсэн судалгаанууд ямар

юм байдаг юм бэ? Ийм хоёр дахь асуулт байна.

Дараагийн асуудал. Одоо энэ шүүгчдийн боловсролын асуудал байгаа.

Монгол чинь их олон дээд сургуультай шүү дээ. 80, 90 дээд сургуультай. Тэндээс төгссөн янз бүрийн улсууд шүүгч болдог. Алдаатай шийдвэр гардаг. Нөлөөлөлд автдаг. Тэрийг нь дээд талын дээд дээд шатны шүүхүүд нь залруулаад явдаг юм шиг байгаа юм.

Тэгэхээр энэ ингээд яваад байх ёстой юм уу? Ер нь боловсролыг дээшлүүлэх. Ёс зүй гэдэг юм байна. Тийм ээ. Нөлөөллөөс ангид байлгах энэ чиглэлд юу хийгдэхээр та нар төлөвлөж бодож ирж байгаа вэ?

Дараагийн асуудал. Одоо энэ шүүхийн ил тод, энэ шийдвэр гаргалтад ард иргэдийн хяналт энэ байхад юу гэхээр энэ цахим болгох асуудал, блокчэйн технологийг ашиглах асуудал хамгийн чухал асуудлын нэг болж орж ирж байгаа юм.

Тэгэхээр энэ шинэчлэлийн хүрээнд цахим болгох, ил тод байлгах, шүүхийн шийдвэрийн платформыг иргэд нээлттэй үздэг хардаг энэ чиглэлд та нар юу болгож, юу бодож орж ирж байгаа вэ гэсэн ийм асуудал байгаа.

Тэгээд энэ чиглэлийн асуудлуудад та нар юу бодож ирсэн бэ? Урд талын энэ алдаатай зүйлүүдийг засах чиглэлд юу бодож оруулж ирэв гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Б.Баттөмөр даргын асуултад хариулъя.

Хуулийн төсөл санаачлагч
Дамдины Цогтбаатар хариулъя.

Д.Цогтбаатар: Хэлэлцүүлгийн тухайд гэвэл яг энэ Их Хурлын завсарлагын үеэр Дээд шүүх дээр би очиж ажилласан.

Тэгэхэд хамгийн анх энэ санааг Дээд шүүхийн шүүгчид өөрсдөө гаргасан.

Үүний дагуу Дээд шүүх дээр өмгөөлөгчдийн холбоо, шүүгчдийг бүгдийг нь оролцуулсан хэлэлцүүлэг явуулсан.

Яг энэ үеэрээ шүүхийг нээлттэй болгох асуудлуудаа ярьж ерөөсөө энэ дээр бүгдээрээ дэмжсэн. Дэмжихээс ч аргагүй. Яагаад гэвэл байгаа хууль маань ийм.

Дэлхий дахинд угаасаа шүүх өөрөө нээлттэй байдаг. Манайд яг хэрэгжүүлэх процессын хуульд байгаа энэ асуудлуудаасаа ялангуяа албан байгууллагууд шууд өөрсдөө үзэмжээрээ тодорхой асуудлаа нууцалчих боломжтой ийм тогтолцоо байгаа учраас үүнээсээ болоод шүүх нээлттэй хуралдах боломж хязгаарлагдчихаад байгаа, эсхүл хаалттай хуралдах үүд хаалгыг нээж өгчхөөд байгаа юм.

Тэгэхээр энэ үүднээсээ яг тэр хэлэлцүүлгийн үеэр ерөөсөө энд оролцсон бүх хүмүүс дэмжсэн.

Ер нь бүх түвшний энэ шүүх, хууль зүйн чиглэлийн салбарын мэргэжилтнүүдийн хэлэлцүүлэг дээр хамгийн бодитой ярьж байдаг юм бол энэ шүүхийн нээлттэй байдлын тухай асуудал байгаа юм.

Шүүхийн практик дээр ч гэсэн одоо яг сая бид өөрсдөө мэдэж байгаа шүү дээ. Энэ нүүрсний хэрэг гэдгийг чинь улс орон даяараа мэдээд юу болсон, яасныг нь мэдээд байхад шүүх хуралдаан нь болсон чинь нээж чадахгүй хаалттай хуралдаад байдаг. Энэ тэгэнгүүт бүр ард иргэдийн илүү их хардалтыг төрүүлж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр иймэрхүү асуудлуудыг давтуулахгүйн тулд үүнийг ерөөсөө нээлттэй хийх зарчим руу шилжүүлж байгаа юм.

Тэгэхээр практик талаасаа ч гэсэн яг бодит бид сая практик дээр л өөрсдөө харлаа шүү дээ. Энэ ийм юм ерөөсөө байж болохгүй гээд, цаашаа үргэлжилж болохгүй гээд.

Шүүгчийн боловсролын асуудал нь зөв зүгээр. Яг энэ хуулийн хүрээнд яригдаагүй. Үүнийгээ цаашдаа бид зайлшгүй ярих ёстой.

Энэ дээр харин тэр нөгөө шүүгчийн туслахуудын асуудал дээр энэ асуудал орж ирж байгаа. Гэхдээ энэ шууд таны асууж байгаа асуулттай хамаагүй. Нөгөө шүүгчийн боловсролын тухай асуудал биш.

Гэхдээ зарчмын хувьд таны тавьж байгаа асуудал маш зөв өө.

Энэ ард иргэдийн хяналт, шийдвэрийг нээлттэй байлгах. Энэ дээр цахимжуулах асуудал маш зөв. Би энэ дээр санал нэг байна.

Энд Н.Учрал сайд өөрөө сууж байна. Монгол Улсыг ер нь зөвхөн шүүх биш төрийн тогтолцоо, үйлчилгээг бүхэлд нь цахимжуулах тал дээр маш их анхаарч ажиллаж байгаа.

Шүүх дээр ч гэсэн маш олон платформууд хэрэгжээд нэвтрээд орчихсон байгаа.

Харин Н.Учрал сайдтай би нэг бус юу ярьж байсан гэхээр шүүхийн олон платформууд хэрэглэж байгаа юм билээ. Эд нар нь хоорондоо харилцан уялдахгүй байгаа нэг ийм сул тал байгаа. Энэ дээр зайлшгүй анхаарч ажиллах хэрэгтэй.

Энэ орж ирснээр харин шүүх өөрөө дижитал болж бүх ярилцаж хэлэлцсэн асуудлууд энэ дээрээ видео бичлэгтэй, тэгээд онлайн байх боломжийг нээж өгөх тал дээр асуудал яригдаж байгаа.

Мэдээж энэ дээр нь сая Байнгын хороон дээр ярьж байхад Засгийн газрыг харин мөнгийг нь сайн тавьж өгөөрэй.

Тэгэхгүй бол авлигачид мөнгөөрөө үүнийг нуух боломжтой байгаад Монголын төр үүнийг нээх мөнгийг нь гаргаж өгөхгүй бол авлигачдын мөнгөнд Монголын төр дийлдэж болохгүй шүү. Тавих мөнгийг нь тавьж өгөөрэй гэдэг асуудлыг сая Байнгын хороон дээр тавьсан байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Баагаагийн Баттөмөр дарга тодруулж асууя.

Б.Баттөмөр: Энэ шүүхийн тухай хууль хэлэлцэж байхад шүүхийнхэн яагаад байхгүй байгаа юм. Дарга аа.

Ажлын хэсэг энэ тэр, шүүхийнхэн байдаггүй юм уу? Аан..? Ямар сонин юм бэ? Харин тийм. Оруулъя л даа. Оруулж байж ярья л даа. Энэ чинь одоо яаж байгаа юм. Аан..?

Энэ авлигыг бууруулах үндсэн гол асуудал энэ **“шударга шүүхийн тогтолцоо”** шүү.

Шүүхийн шинэчлэлийг эрчимтэй сайн хийх ёстой. Мөнгөтэй хүмүүст үйлчилдэг, дарга дарга цэрэг нарын цүнх барьж гүйдэг ийм хүмүүс шүүгчээр томилогддог.

Ийм учраас шүүхийн шинэчлэлийг хийх ёстой.

Дараагийн асуудал нь орон тоог бууруулдаггүй юм гэхэд өсгөж болохгүй шүү.

Л.Мөнхбаатар: Н.Учрал сайд үг хэлэх байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал асуултаа асууя.

Н.Учрал: Би хууль санаачлагч.

Тийм болохоор үгэн дээрээ нэмээд хариулчихъя.

Өнгөрсөн хугацаанд шүүхийн ил тод байдлыг хангуулах чиглэлээр сая өнгөрсөн хугацаанд 109 хууль дээр өөрчлөлт оруулсан шүү дээ. Нөгөө цахим хэлбэрээр бичиг баримтыг бүрдүүлэх, цахим хэлбэрээр байж болно гэдэг заалтуудыг.

Тэгээд тухайн үед Улсын дээд шүүх болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс яг энэ **“иргэний процесс”**, **“эрүүгийн процесс”**, **“захиргааны процесс”**-той холбогдуулаад энэ асуудлуудыг тухайлан авч үзэх ёстой.

Тийм учраас энэ **“иргэний процесс”**, **“эрүүгийн процесс”**, **“захиргааны процесс”** дээр заавал энэ

удаа тэр 109 хуулийн хүрээнд шийдвэрлэх шаардлагагүй гээд энэ шүүхийн хуулийг энэ удаа Шүүхийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлууд дээр шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэхээр тодорхой зохицуулалтуудыг Г.Занданшатар дарга, Д.Цогтбаатар гишүүн, Д.Тогтохсүрэн дарга бид дөрвийн одоо энэ санаачилсан хуулиуд дээр оруулж өгч байгаа.

Тэгээд яг өнгөрсөн хугацаанд бид төрийн мэдээлэл солилцооны “ХУР систем”-ээр шүүхийн цахим лавлагааны нийт 18 лавлагааг мэдээлэл солилцдог болгосон.

Гэсэн хэдий ч яг өнөөдөр амьдрал дээр шүүх хурлыг нээлттэй явуулахыг зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа юм.

Тэгээд нээлттэй явуулах буюу түүнийг нь шууд дамжуулах. Тэгээд дээрээс нь хэдийгээр нөгөө цахим нотлох баримтыг үнэлдэг ч гэсэн жишээ нь энгийн амьдрал дээр шүүх хуралдааны товыг цахимаар товоо хойшлуулах эрх зүйн боломж одоо хуулийн хүрээнд байхгүй.

Тийм учраас иргэд хотын төв рүү ирээд заавал нөгөө бичгээр шүүх хуралдааны товыг хойшлуулдаг.

Тэгэхээр энэ бол цаанаа маш их хүнд суртлын бий болгодог.

Уг нь нэхэмжлэхийг ч гэсэн цахимаар л гаргачихмаар байгаа юм л даа.

Тэгэхгүй заавал хотын төв рүү ирээд л нэхэмжлэхийг заавал бичгээр гаргадаг.

Тэгэхээр шүүхийнхнийг ч гэсэн та нар нэхэмжлэхээ цахимаар гаргахыг зөвшөөр, та нар товыг хойшлуулахыг цахимаар зөвшөөр гээд тэгэхээр хуульд нь цагаан дээр хараар биччихсэн юм чинь энэ чинь боломжгүй шүү дээ.

Тэгэхээр энэ хуулийн хүрээнд бид шүүх хуралдааныг цахимаар явуулахыг ч зөвшөөрч болно гэдгийг нь нээж өгье.

Дээрээс нь тэр шүүх хуралдааны товыг хойшлуулах, цахим хэлбэрээр өргөдөл, гомдлуудыг нь авах, бүх асуудлыг нь нээж өгье. Цахимаар ч болно, цаасаар ч болно гээд.

Үүний дараа мэдээж Засгийн газраас магадгүй сонгуулийн дараа төсвийн тодотгол хийх юм бол энэ дээр нь төсөв мөнгийг нь тавьж өгөөд, шүүх эрх мэдлийн байгууллагуудыг илүү технологийн хүрээнд төсөв мөнгийг нь нэмэгдүүлэх дээр энэ хууль батлагдчих юм бол хуулиа дагуулаад төсвүүдийг нь тавиад өгөх бололцоо бүрдэнэ гэж бодож байгаа.

Тэгээд ер нь цахимжилт явсаар байгаад хамгийн эцсийн үр дүнд эрх зүйн үр дагавар үүсэх тэр цаг үе буюу шүүх дээр ирээд л яг ингээд гацаж байгаа юм билээ.

Тийм учраас цаашдаа хуулийнх нь хүрээнд нээе. Хуульдаа тааруулж, хуульдаа нийцүүлж бид төсөв мөнгөө ч нэмэгдүүлье. Энэ хүрээнд мэдээж шүүх өөрөө бие даасан хараат бус байх зарчим байгаа ч гэсэн үүний цаана технологийн хувьд хараат бус байх ёстой.

Тийм учраас Б.Баттөмөр гишүүний хэлж байгаа блокчэйн дээр бүртгэх, блокчэйн буюу кодлогдсон

хараат бус байх энэ технологийг шүүхийн процесст бүрэн оруулж өгч байж л шүүхдээ технологийн хувьд ч, хуулийнхаа хувьд ч итгэх итгэл үнэмшил дагаад дээшилнэ.

Тийм учраас Шүүхийн нэмэлт, өөрчлөлтийн хууль бол эхний том гараа болно гэж ингэж ойлгож.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Н.Учрал гишүүн хууль санаачлагчдын хувьд нэмж байр сууриа илэрхийлж үг хэллээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Санал хураалт явагдана. Гишүүд байраа эзэлье. Гишүүд байраа эзэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр үг хэлье.

Б.Энхбаяр: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Засгийн газар мөн дэмжсэн санал өгсөн.

Тэгэхдээ хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа хэлэлцүүлгийн шатад хуулийн төсөл дээр Байнгын хороо ажлын хэсэг дээр нэлээн анхаарах хэд хэдэн асуудлууд байгаа.

Нэгдүгээрт, гол үзэл санаа бол ер нь төрийн нууцаас бусад шүүх хурлуудыг нээлттэй хийдэг байя. Яг өсвөр насны хүүхэдтэй холбоотой, хохирогчтой ийм хэргүүдийг бас хүсэлтээр хаалттай хийж болно.

Авлига, албан тушаалын гэмт хэргүүдийг хаалттай хийхгүй ээ гэдэг ийм суурь асуудлууд байгаа.

Шүүхийн тухай хуулийг 2021 онд баталж байхад манай шүүхийн бас нэг лобби хүчтэй байсан юмнууд байгаа юм.

Тэгээд тэнд хасагдаад бид 3 жил болчихсон юмыг бас шүүхийнхэн оруулж ирэх гээд нэг, хоёр юм шургуулчихсан байна. Тийм.

Тухайлбал, шүүгчдийг зэрэг дэвтэй болгох асуудлыг оруулж ирчхээд байгаа юм.

Тэгээд шүүх гэдэг бол шүүгчээсээ хараат бус байх ёстой. Бид 2021 онд Шүүхийн тухай хуулийг батлахдаа хэд хэдэн зарчмыг барьсны нэг нь шүүхийг, шүүгчийг, шүүгчээс нь ч хараат бус болгох зарчим баримталсан юм.

Өөрөөр хэлбэл дарга шүүгчийн тогтолцоог халсан гэсэн үг. Бие биедээ даргалахгүй ээ, захирахгүй ээ, би дарга шүүгч гэдгээр доод шүүгчдээ нөлөөлөхгүй ээ гэдгийг бид 2021 онд шүүхийн хуулиар хийж өгсөн байхгүй юу.

Тэгсэн чинь нөгөө хэд маань орж ирээд шүүхийн тэргүүн түшээ, дэд түшээ, гутгаар түшээ, дөтгөөр түшээ, тавдугаар түшээ гээд ингээд баахан дээрээ би илүү том тэргүүн түшээ нь, чи тавдугаар түшээ нь гээд ингээд бие биедээ дарга болох юм оруулаад ирчихсэн байх юм.

Тэгээд энэ чинь шүүх гэдэг чинь, шүүгч гэдэг чинь хэн нь ч хэндээ дарга биш байхгүй юу.

Нэг шүүгч нөгөө шүүгчдээ даргалахгүй, томрохгүй.

Би 30 жил болсон юм аа. Атаман шүүгч ээ. Чи одоо нэг жил болсон шүүгч ээ гээд ингээд бие биеэ ингээд дээрэлхээд байдаг юм шүүх дотор байж болохгүй ээ.

Тийм учраас энэ зэрэг дэв гэдэг юмыг нь бид авч хаясан юм. 2021 онд.

Тэгээд үүнийгээ буцааж санагалзаад оруулаад ирчихсэн байгаа юм. Үүнийг хэлэлцүүлгийн явцад хасах ёстой.

Хоёр дахь юм бол энэ Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи гэдэг юм оруулж ирчхээд байгаа юм.

Тэгээд бид 2021 онд Улсын дээд шүүхийн дэргэд “Шүүхийн сургалт, мэдээллийн хүрээлэн” гэж байгуулсан. Судлаач туслахуудыг гаргаж өгсөн, судлаачтай болгосон. Сүүлд орон тоог нь нэмж өгсөн. Одоо нэлээн тийм бэхэжсэн.

Энэ нь өөрөө бас үр дүнтэй байгаа. Үүнийг би дэмжиж явдаг. Зөв байсан гэж үздэг.

Тэгээд үүнийгээ нэлээн тийм хуульчийн лицензтэй нь холбоод тэгээд заавал хамрагдах болгоод эндээ суухгүй бол тэр хуульчийн лиценз нь хүчингүй болчих ч юм шиг, цаад утгаараа шүүгч байх эсэх нь тэндээсээ хамаарчих ч юм шиг.

Энэ нь өөрөө академи нь болохоор Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийнхээ дэргэд байгаад байгаа байхгүй юу.

Тэгэнгүүт би шуудхан хэлэхэд ингэж хардах гээд байна л даа. Ерөнхий шүүгч хүрээлэнгээрээ дамжуулаад бусад шүүхдээ сургалтад суусан, сурах ёстой

юмаа сураагүй, мэдээгүй гээд нөгөө лицензийг нь хүчингүй болгох замаар шүүгчдэдээ нөлөөлчих ийм.

Өөрөөр хэлбэл дахиад хонгил угсрагдах ийм юм би орж ирчхээд байна уу гэж би хардаад байгаа юм.

Засгийн газар дээр надад энэ саналыг тавьж байсан юм. Би хүлээж аваагүй юм. Тэгээд хүлээж аваагүй хоёр юмаа ингээд шургуулчихсан байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр хэлэлцүүлгийн шатад бид энэ 2021 онд шүүхийн энэ хонгилыг нураасан, процессыг нь жоохон дотоод ардчилалтай болгосон, бие биеэс нь хараат бус болгосон энэ юмаа нэг тогтвортой хэдэн жил хадгалахгүй бол бас л их улс төрийн мэдрэмжтэй байна шүү, манай шүүхийнхэн.

Яг сонгуулийн үеэр энэ хэд анзаарахгүй, аягүй бол баталчхаж магадгүй гээд ингээд оруулаад юм шургуулчхаж байгаа байхгүй юу.

Би хуулийн хулгайтай тэмцэнэ гэж 2020 онд хэлсэн. Энэ нь дуусан дуусталаа л хуулийн хулгайтай тэмцэнэ. Тийм. Бүх заалтуудыг нэг бүрчлэн харна.

Тийм учраас ийм хуулийн хулгай хийх боломж олгохгүй л гэж хэлмээр байна.

Л.Мөнхбаатар: Энэ асуулт хариулт биш л дээ. Гишүүд үг хэлж байна.

Б.Энхбаяр сайдын хэлж байгаа зүйл яах вэ хэлэлцэх эсэх асуудал байна шүү дээ. Өнөөдөр бол.

Байнгын хороон дээрээ энэ асуудлаараа ярина биз.

Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хороон дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан үг хэлье. Гишүүд байраа эзлээрэй. Одоо санал хураана шүү.

Б.Энх-Амгалан: Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах энэ хуулийг би дэмжиж байгаа. Хоёр гараа өргөөд дэмжиж байгаа.

Тэгээд хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүгчийн захирамж, тогтоол, шүүхийн шийдвэрийг хувилж авах, шүүх хуралдааны бичлэгийг авах, өмгөөлөгч нарт олгодог байх, өмгөөлөх боломжоор нь хангах энэ асуудал их чухал байгаа юм.

Түүнээс гадна хэрэг эхэлснээс авхуулаад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатад авагдсан гэрч, хохирогчийн мэдүүлэг, хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтууд, тэр явцдаа авсан мэдүүлгийг авахдаа авсан бичлэгүүдийг өмгөөлөгч авдаг байх ёстой.

Хэргийн материалтай танилцана гээд ороод танилцуулахдаа эндээс материал хувилж авъя гэхээр зэрэг хувилж авахгүй ээ, бичиж ав гэдэг ийм гаж тогтолцоо байгаа юм.

Тэрийг хувилж ч авч болдог, цахимаар ч авч болдог, хуулаад ч авч болдог, канондоод ч авч болдог л байх ёстой. Тэгж байж энэ хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал

хангагдана гэж үзэж байгаа юм. Энэ маш зөв хууль.

Ингэж байж ил тод болно. Ингэж байж гэм буруутай юу, үгүй юу гэдэг нь тодорхой болно.

Зөвхөн улсын нууцтай холбоотой, төрийн нууцтай холбоотой, үндэсний аюулгүй байдалтай холбоотой хуулиар нууцлагдсан энэ асуудлыг хэлэлцэхэд хаалттай байж болж байгаа юм.

Бусад асуудал дээр нээлттэй байх ёстой.

Тэр гэр бүлийн асуудал дээр, ялангуяа тэр бага насны хүүхдийг хүчиндэх болоод тэр хүчингийн хэрэгтэй холбоотой зарим нэгэн асуудал дээр шүүх өөрийн дотоод үзэмжээрээ хаалттай болгох асуудал нээлттэй байх ёстой. Тэр хүүхдийн асуудлыг хаалттай хэлэлцэх ёстой.

Бусад тохиолдолд. Тэр залилангийн, өмч хөрөнгийн, газрын маргааны, тэгээд өр төлбөртэй холбоотой асуудал байдаг юм уу, бусад бүх асуудал дээр энэ нээлттэй байж цаашдаа энэ чинь хүн бол шүүх дээр очих юм бол нээлттэй ярилцана.

Тийм учраас үүнийг энэ дээр нотлох баримт дээр асуудал тулгуурлаж гарна гэдэг ийм юм гарах учраас тэнд ямар нэгэн захиалгын юм явахгүй. Тэнд нөгөө яриад байдаг хонгилын шүүгч гэдэг асуудал яригдахгүй.

Тэнд зөвхөн нотлох баримт дээр тулгуурлагдсан шүүхийн хараат бус байдал шийдвэр гаргахад нь их тодорхой нөлөөлөх, шүүгчийн өөрийнх нь итгэл үнэмшилд тодорхой нөлөөлөх ийм асуудал байгаа юм.

Гэм бурууг нь тогтооход тэнд яг ийм нотлох баримтаар нотоллоо гэдэг юм гарах юм бол тэр шударга болж байгаа юм.

Тийм учраас энэ хуулийг дэмжиж байгаа гэдгийг хэлье.

Хэлэлцүүлгийн явцад тэр асуудлуудыг нэлээн нарийн оруулах ёстой.

Би өглөө Байнгын хорооны хурал дээр нэг зүйл хэлсэн. Тэр нь юу вэ гэхээр зэрэг шүүх хуралдааны бичлэг хэдий хугацаанд хадгалагдах юм. Нэг өдөрт 130, 140, 150 шүүх хурал болно. Нэг шүүх хуралдааны бичлэг 3, 4 өдөр үргэлжилнэ.

Тэрийг бүгдийг нь ил болгох юм уу, эсвэл тодорхой хэсгийг нь ил болгох юм уу, эсвэл тэр хуралдсан хуралдааны бичлэг тусгай парламент суваг гэдэг шиг шүүхийн суваг байх ёстой юм уу. Тэр ямар хугацаанд хадгалагдах ёстой юм, ямар хугацаанд архивлагдах ёстой юм гэдэг асуудлыг энэ хэлэлцүүлгийн явцад тодорхой болгож өгөөрэй гэж хүсэж байгаа юм. Тэгээд хуулийг дэмжиж байгаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд танхимдаа байраа эзэлье. Саналын томьёололыг танилцуулна. Гишүүдээ байраа эзлээрэй.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая.

Саналын томьёоллоор уншиж танилцуулсан. Гишүүд байраа эзлээрэй.

Санал хураалтыг түр хойшлууллаа.

Дараагийн асуудлыг хэлэлцээд санал хураалтыг нэгтгэж явуулна. Хоёулаа шүүхийн асуудал байгаа юм.

Долоо.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурал хурлын гишүүн Дашдондогийн Ганбат танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Д.Ганбат: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Хууль зүйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгатай холбогдуулан хуралдаанд оролцсон гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан нэг санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 6 санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулга болон зарчмын

зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Д.Ганбат гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Дашдоржийн Мөнхтуяа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Лхагвадоржийн Энхбилэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Навагчамбын Баасанжав, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Амгалангийн Насандэлгэр, Улсын Ерөнхий прокуроын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Отгонбаярын Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль тогтоомжийн хэлтсийн дарга Энэбишийн Бадамсамбуу нар оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Д.Ганбат гишүүнээр тасаллаа.

Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат асуулт асууж.

Д.Ганбат: Бид бүхэн шүүхийг янз бүрээр хэлдэг. Уг нь хуулиараа ийм байх ёсгүй л дээ. Шүүхэд бүгдээрээ л хүндэтгэлтэй хандах ёстой.

Хамгийн иргэншсэн нийгмийн наад захын нэг шаардлага бол шүүхээс ямар ч шийдвэр гарсан биелүүлж байх ёстой. Шүүхийн шийдвэр эцсийн байдаг.

Хуучин 70 жил тэр нам, янз бүрийн байгууллагууд нь тэгээд л хэлэлцээд шийдвэр гаргадаг байсан бол одоо тийм биш болсон. Ингээд 30 жил явж байна.

Алдаа оноотой ч гэсэн Монгол Улсын шүүх засаглал өдрөөс өдөрт, жилээс жилд сайжирч байгаа.

Би өнөөдөр онцлон дурдъя. Энэ олонх маань бас хайр нь гаднаа, хал нь дотроо юм шиг хамгийн сүүлд манай Монгол Ардын намын дарга бид хоёр сайн муугаа нэлээн дуудалцдаг л даа. Гэхдээ Засгийн газраас энэ хуулийг оруулж ирээд ингэж баталж байгаа нь дэмжүүштэй юм. Энэ зөв зүйтэй асуудал.

Үүний өмнө тогтоол баталсан. Энэ 10 жилдээ манай Хууль зүй, дотоод хэргийн сайд, энэ Засгийн газрын анхаарч ажиллах ёстой ийм зүйл мөн гэж үзээд 350 тэрбум төгрөгийг тусгасан байгаа.

Шүүх ингээд өөрчлөгдөх байх.

Жилээс жилд 70 мянган иргэн нэмэгдэж байгаа шүү дээ. Энэ чинь бүхэл бүтэн аймаг байхгүй юу. Бүхэл бүтэн аймаг нэмэгдэж байхад яг орон тоо нь 600, 700 хүрэхтэй үгүйтэй байгаа.

Шүүх чанартай үйлчилгээ үзүүлж, хараат бусаар асуудлыг шийдэх ёстой. Одоо шүүхээр ордоггүй, харьцдаггүй, үйлчилгээ авдаггүй хүн байхгүй болсон.

Энэ бол одоо хууль эрх зүй, хуулиа дээдэлсэн нийгмийн хамгийн наад талын шаардлага. Өдрөөс өдөрт, жилээс жилд тийм болж байна.

Үүнийг гүйцэж алхахад бид бүхний дэмжлэг, хууль тогтоогчдын

дэмжлэг нэг их сайн биш байгаа. Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөл тэндээ шүүхийн хараат байдлыг хангахын тулд энэ орон тоон дээрээ анхаарах ёстой. Нэг шүүгчид байгаа ажлын ачаалал ямар байна вэ?

Уг нь хэвийн хэрэг шийдэх нэг шүүгчийн ачаалал 200, 300 байх ёстой байх. Миний ойлгосноор 400, 800 хүртэл хүрч байна гэнэ. Ийм ачаалалтай хэрэг шийдэж байгаа шүүгчийн ажлын ачаалал ямар байх вэ, гаргаж байгаа шийдвэрт нөлөөлөх үү? Энэ тал дээр та бүхэн анхаарсан уу?

Тэгээд одоо Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо Та бүхэн маань шүүгч нар чинь энд тэнд илүү дутуу зүйл яриад явж чаддаггүй шүү дээ. Энэ олон нийтийн ойлголтыг зөв болгож өг өө. Энэ талаар Та бүхэн ажиллаж байгаа юу, ямар байгаа вэ гэдгийг асууж лавламаар байна.

Би тодорхой хэмжээнд мэдэж байна.

Гэхдээ Та бүхэн нэгэнт шүүхийнхээ хуулийг хэлэлцүүлээд ингээд батлуулах гэж байна. энэ шат нь явж байна. Эцсийн хэлэлцүүлэг нь явж байна.

Энэ дээр Монголын ард түмэнд ямар байх ёстой юм, ямар ачаалалтай байгаа юм гэдгийг товчхон тодорхой хариулаад өг өө. Өнөөдрийн шаардлага энэ юманд нийцэж байна уу, ямар байгаа билээ гэдгийг тодруулаад хэлээд өг өө гэсэн ийм юмыг хэлж байна.

Энэ чинь бас нөгөө шүүх хараат бус байх, шүүх шударга байх, энэ нийгэм хуулийг дээдэлдэг байх. Тэгээд энэ

бүхэнтэй чинь холбоотой гэж би үздэг юм.

Угаасаа энэ ардчилсан нийгэм тийм л байх ёстой.

Л.Мөнхбаатар: Төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын асуултад хариулъя.

Хэн хариулах вэ? Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг хариулъя. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

Л.Энхбилэг: Гишүүддээ үдийн мэнд хүргэе.

Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Д.Ганбат гишүүндээ төрсөн өдрийн мэнд хүргэе.

Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

2023 оны шүүн таслах ажлын мэдээ гарсан. Бид 2021 оны шинэ хуулиар бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилласнаас хойш бид судалгаа хийсэн. Шүүгчийн ажлын ачааллыг тооцохоор.

Бидний судалгаагаар эрүүгийн хэрэг дээр 105, иргэн дээр 209, захиргаан дээр 50 орчим хэргийг жилдээ шийдэх юм бол зохист ачаалал гэж үзэж байгаа юм.

Одоо бол яг үүнээс 200 дахин давчихсан ийм ачаалалтай шүүгч нар ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар яг гар дээр нь иргэн дээр жишээ татахад Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх дээр 280-аас 350 орчим хэргийн үлдэгдэлтэй гар дээрээ байгаа.

Түүнчлэн ачаалал үүсээд байгаа гол шалтгаан бол өөрөө яг энэ ажлын байртай холбоотой. Үүнийг удаа дараагийн чуулган дээр хэлж байгаа. Байнгын хороон дээр ч хэлж байгаа.

Ерөнхий зөвлөл энэ ачааллыг багасгах, хүний нөөцийг бүрдүүлэх тал дээр тасралтгүй ажиллаж байна.

Бид бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилласнаас хойш нийтдээ 7 дахь удаагийн сонгон шалгаруулалт явагдаж байна. Өнөөдөр 7 дахь удаагийн сонгон шалгаруулалт эхэлчихсэн явж байгаа.

2016 оны 42 дугаар тогтоолоор нийт Монгол Улсад 699 шүүгч ажиллана гэсэн тоо тогтоож өгсөн.

Одоо бид энэ шүүх байгуулах хуулиараа 699-өөсөө дотроо шүүхээ байгуулахаар төлөвлөөд явж байгаа.

Орон нутагт ачаалал харьцангуй тэнцвэртэй байгаа. Зарим орон нутагт хүн амын нягтаршил, хэрэг маргааны төрлөөсөө шалтгаалаад харьцангуй өндөр байдаг. Жишээ нь, Төв аймаг, Дархан, Орхон-Уул аймагт ачаалал өндөр байгаа. Хөвсгөл аймаг ч мөн өндөр байгаа.

Дүүргийн шүүхүүдийн ачаалал хэрээс хэтэрчихсэн. Ингээд 200-аас 250 хувь хэтэрсэн. Тэгээд Шүүхийн тухай хуулийнхаа дагуу шүүгч нарт хэтэрсэн ачааллаас нь тооцоод нэмэгдэл урамшууллын олгож яваа.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу? Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Би нэг зүйл тодруулчихъя гэж бодож байна.

Одоо нөгөө шүүх, шүүгчдийг тэр хараат бус ажиллах нөхцөл боломжийг хууль тогтоогчид болон Шүүхийн ерөнхий зөвлөл хангаж ажиллах ёстой.

Танай хууль дээр ч тийм зүйл заалт байгаа байх. Эдийн засгийн хувьд боломжтой ажиллах ёстой.

Монгол Улсын эдийн засаг хэд дахин томорсон. Ялангуяа төсвийн байгууллага 5, 6 дахин болчихсон байгаа.

Тэгээд ажиллах шүүгч нар олдохоо байсан гэж би дуулсан. Хуучин нэг орон тоон дээр 5, 6 хүн өрсөлддөг, хамгийн шилдгүүд нь орж ирж ажилладаг байсан. Тийм ч байх ёстой. Шүүгч бол хуульч хүний хамгийн дээд талын хүн болгоны хүрэхийг хүсдэг ийм карьер гэж ойлгож байгаа.

Одоо цалин цавуу нь ямар байгаа вэ? Энэ мөнгөний ханш уналттай холбогдоод.

Тэр эдийн засгийн баталгааг нь хангахаар тийм боломж бололцоо хуульд заасан тэр юмыг нь хангаж чадаж байгаа юу гэдгийг асууя.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг хариулъя.

Л.Энхбилэг: Шүүгчийн цалин нэмэгдээгүй 10 гаруй жил болсон.

Өнгөрсөн хугацаанд 58 хувиар нэмж өгсөн. Оны сүүлд. Одоо бид бас энэ шүүгчийнхээ цалинг нэмэгдүүлэх, зэрэг дэвийг нь олох талаар санаачлаад судалгаа хийгээд явж байгаа. Тэгээд үр дүн гарна гэж найдаж байна.

Л.Мөнхбаатар: Гишүүд байраа эзэлье. Одоо санал хураалт явагдана. Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд байраа эзэлье. Гишүүд танхимдаа орж ирье.

Энэ хооронд Шүүх байгуулах тухай хууль батлагдаж байгаатай холбогдуулан үг хэлье.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр шүүхийг тойргийн зарчмаар байгуулах эрх зүйн үндэс бүрдсэн.

Үүний дагуу Улсын Их Хурал өнөөдөр Шүүх байгуулах тухай хуулийг батлах гэж байна.

Энэ хуулиар анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж, маргааны төрлөөр дагнасан хоёр шинэ шүүх буюу “Гэр бүл, хүүхдийн дагнасан шүүх”, “Хялбар ажиллагааны шүүх” ажиллах нөхцөл ийнхүү бүрдэж байна.

Шүүх байгуулах хууль батлагдсанаар шүүхийн үйлчилгээг иргэдэд хүргэх зохион байгуулалтад өөрчлөлт орж, шүүгчийн ажлын ачаалал тэнцвэржиж, үйлчилгээ мэргэшсэн тэр хэрээр иргэдэд хүртээмжтэй, шуурхай, чанартай болох ёстой.

Мөн анхан шатны шүүхүүдийг тойргийн зарчмаар байгуулахдаа алслагдсан Багануур дүүргийн шүүхийн одоогийн зохион байгуулалтыг хэвээр үлдээж, шүүхийн үйлчилгээ хүртээмжтэй байх нөхцөлийг хангалаа.

Түүнчлэн шүүхэд шүүгчийг татгалзан гаргах, шүүгч өвдөх, шүүгчийн орон тоо гүйцээгүй зэрэг шалтгаанаар шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсноос

шүүгч аймаг, сум дамнан өөр шүүхэд томилолтоор ажиллах шаардлага их гарч байна.

Одоогийн энэ тогтолцоогоор цаашаа бүр эдийн засгийн хувьд үр өгөөжгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарт болон шүүгч хэргийн материалтай танилцах хугацаа хомс байх зэрэг сөрөг үр дагавар үргэлжилсээр байх тул шинээр баталсан энэ хуулиар аймаг дахь эрүү, иргэний анхан шатны шүүхийг нэгтгэлээ.

Мөн Орхон, Дархан-Уул аймгийн эрүү, иргэний шүүх тусдаа үйл ажиллагаа явуулна.

Ингэснээр шүүхүүд тухайн аймгийнхаа нийгэм, эдийн засгийн онцлог, хэрэг маргааны төрлөөс хамааран дотроо дагнасан танхимын зохион байгуулалттайгаар ажиллах ийм боломжтой болно.

Үүгээрээ Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан “анхан шатны шүүх шүүн таслах үйл ажиллагааны төрлөөр дагнасан танхимтай байж болно” гэсэн энэ зохицуулалт хэрэгжих суурь мөн бүрдэж байна.

Монгол Улс ардчилсан хууль дээдлэх зарчимд тулгуурласан Үндсэн хуулиа баталснаас хойш Захиргааны хэргийн дагнасан шүүхийн тогтолцоог нэвтрүүлж, 20 жилийн дараа дагнасан шүүхийн тогтолцооны хөгжлийн дараагийн үе шат руу шилжиж байна.

Шүүх байгуулах тухай энэ хуулиар Монгол Улсад

■ 2026 оноос “Гэр бүл, хүүхдийн дагнасан шүүх”;

■ 2025 оноос “Хялбар ажиллагааны дагнасан шүүх” ажиллана.

Шүүх байгуулах тухай хууль батлагдсанаар шүүгчийг шинээр байгуулагдсан шүүхэд шилжүүлэн томилоход хуульд заасан шүүгчийн хараат бус бие даасан баталгааг хангахад онцгой анхаарч Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд тухайлан тусгалаа.

Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн ажлын хэсгийн гишүүд шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудад мөн талархал илэрхийлэе.

Ингээд 2021 оноос Шүүхийн тухай хууль шинэчлэн батлагдсан, Шүүхийн сахилгын хороо шинэчлэн байгуулагдлаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийг байгуулахад нийт шүүгчдийн хурлаас нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийн сонсгол хийсэн эрүүгийн болон процессын хуулиудад тодорхой өөрчлөлтүүд орлоо.

Өнөөдөр Шүүх байгуулах тухай хууль ийнхүү эцсийн хэлэлцүүлэг нь хийгдэж байна.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу шүүх эрх мэдлийн хүрээнд батлагдах гол хуулиуд ийнхүү батлагдаж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтыг нэг мөр ханган ажиллаж, хараат бус, шударга, иргэдийн итгэл хүлээсэн шүүхийг бэхжүүлэх шаардлага өндрөөр тавигдаж байгааг шүүх эрх мэдлийн нийт байгууллагууд шүүгч нарт анхаарч ажиллахыг хүсье.

Санал хураалтыг явуулъя. Гишүүд байраа эзлээрэй.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана.

Зарчмын зөрүүтэй 7 санал байна.

Та бүгдэд танилцуулна. Шүүх байгуулах тухай хуульд шинэчилсэн найруулгын зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор танилцуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналууд байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 7, 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7, 8, 13, 14 дэх заалт болгох:

7.Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Дархан-Уул аймаг, Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж;

8.Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дархан-Уул аймаг, Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж;

13.Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Орхон аймаг, Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж;

14.Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Орхон аймаг, Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

55.0 хувиар санал дэмжигдлээ.

Шүүх байгуулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёололыг танилцуулъя.

Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зарчмын зөрүүтэй саналын томьёололыг хэлэлцье.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хуулийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт, Хоёр дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалт, мөн зүйлийн Гурав, Зургаа дахь хэсэгт заасан анхан шатны шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа эрүү, иргэний хэрэг, маргаан, эрүүгийн хэргийн шүүх харьяаллан шийдвэрлэх зөрчлийн хэрэг, маргааныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхэд шилжүүлнэ.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

52.5 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын

зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

“32.6.Ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүх болон сэлгэн ажиллах боломжгүй давж заалдах шатны шүүхээс энэ хуулийн 76.2, 95.4-т заасны дагуу шүүгч гишүүнээр сонгогдсон тохиолдолд тухайн шүүгчийн сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлана.

32.7.Энэ хуулийн 32.6-д заасан шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас нэг жилийн дотор сонгон шалгаруулалт зарлахгүй.””

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

52.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “эсхүл тухайн шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан бол адил шатны өөр шүүхэд шилжүүлэн томилуулах хүсэлтээ Ерөнхий зөвлөлд гаргаж болно.” гэснийг “эсхүл тухайн шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад хуульч бүртгүүлээгүй, шалгалтад тэнцээгүй, томилогдоогүй, сэлгэн ажиллах захиалгаар шүүгч хүсэлт ирүүлээгүй, зохист ачааллаас илүү

ачаалалтай ажиллаж байгаа нь судалгаагаар тогтоогдсон бол дөрвөөс дээш жил ажилласан шүүгчийн зөвшөөрлийг үндэслэн адил шатны өөр шүүхэд шилжүүлэн томилох саналыг Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид хүргүүлж болно.” гэж өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

55.0 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг:

“46.3.Ерөнхий зөвлөл шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг өөрийн батлагдсан төсвийн хүрээнд тогтоож, нэмэгдэл олгох журмыг батална. Улсын дээд шүүхээс бусад шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хуралд тогтооно.””

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

52.5 хувиар санал дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хороо, Б.Энхбаяр сайд нар энэ дээр томьёоллоор тохирчихсон юм байна гэж ойлголоо шүү дээ. Тийм ээ.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн

талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын 3 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

57.5 хувиар санал дэмжигдлээ.

“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын танилцуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх:

“6/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг эрэн сурвалжлах чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай нэгжийн орон тоо, төсвийг нэмэгдүүлэх, холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

Энэ угаасаа тодорхой орон тоо нэмэгдэж таарна шүү дээ. Тийм ээ. Энэ чиг үүрэг шилжсэнтэй холбогдуулаад.

Энэ асуудлаа Улсын Их Хуралд оруулж ирэх чиглэл өгөгдөж байна.

Төсвийн тодотгол хийгдвэл тэр үед мөн оруулж өгөх боломжтой гэдгийг хэлэх нь зүйтэй.

55.0 хувиар санал дэмжигдлээ.

Чухал хууль батлагдлаа шүү. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

Одоо санал хураалт явуулна. Тийм. Өмнөх шүүхтэй холбоотой хуулийн санал хураалтыг явуулна. Ажлын хэсэг байх ёстой билүү, үгүй билүү.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхтэй холбогдуулан саналын томьёоллыг уншиж танилцуулсан байгаа.

Санал хураалт явуулья. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан байгаа.

Санал хураалт явуулья.

56.1 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

Шүүхийн хуулийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэлээ. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

Дараагийнхаа асуудалд орно.

Б.Энхбаяр сайд аа, шүүгчийн зэрэг дэвтэй байх асуудал бол яах вэ өөрөө зарчмын асуудал хөндөж ярьж байна шүү дээ. Тийм ээ.

Үүнээс гадна яах вэ Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хороо нь харин зэрэг дэвтэй гэдэг юм уу, нөгөө захиргааны ажилтнууд шүү дээ. Ер нь

тийм ээ. Тэр нь тусдаа байж болохоор байж болох юм.

Та нар хэлэлцүүлгийнхээ явцад яриарай. Тийм ээ.

Дараагийнхаа асуудалд орёе.

Найм.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаярт танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд 2023 оны 05 сарын 31-ний өдөр оруулсан өөрчлөлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан билээ.

Уг хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар 2024 оны 05 сарын 21-ний өдөр хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Б.Энхбаяр сайдад баярлалаа.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Б.Энх-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, түүний үзэл баримтлал, зохицуулалтад нийцүүлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны

тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулиудад холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгахаар хуулийн төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдааны үеэр хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Б.Энх-Амгалан даргад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Нэргүйн Мягмар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Нармандахын Жамъянхүү, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Жаргалсайханы Амгалан нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Уг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Ц.Идэрбат уу? Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат үг хэлье.

Ц.Идэрбат: Яах вэ, сонгуулийн хууль гараад олон шинэлэг зүйлүүд байгаа. Тэгээд эхнээсээ хэрэгжээд явж байна.

Тэгээд би өнөөдрийн хэлэлцэх гэж байгаа асуудалтай холбоотой биш.

Ер нь сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой зүйлийг Сонгуулийн ерөнхий хорооноос асуух гэж байгаа юм.

Сонгуулийн хууль хэрэгжиж эхлээд, түүн дээр Үндэсний Аудитын газраас сонгуульд зарцуулах мөнгөний дээд хэмжээг зааж өгсөн.

Тэгээд энэ чинь одоо зарим үед хүн итгэхийн аргагүй тийм өндөр дүнг зарлачихсан.

Тэгээд иргэд ойлгохдоо тийм их хэмжээний мөнгөтэй хүн дэвших юм байна гээд ойлгогдож байгаа. Наадах чинь. Тэрбум хэдэн зуу гэж. 200, 300, бараг 500, 600 ч болж байгаа байх.

Тэгэхээр яг ямар үндэслэлээр тэрбум хэдэн зуу гэдэг энэ тоог гаргаж ирснийгээ бас нэг тайлбарлуулмаар байгаа юм.

Зүгээр сонгуульд орохын төлөө тийм их мөнгө зарцуулна. Авч байгаа цалин чинь хэд билээ гээд жирийн иргэн ч гайхаад сууж байгаа шүү дээ.

Тэгээд энэ чинь өөрөө Их Хурал, энэ сонгуулийн нэр хүнд, янз янзын юманд иргэдийн дунд буруу ойлголт яваад байна.

Тэгэхээр энэ дээр ер нь Сонгуулийн ерөнхий хороо ямар байр суурьтай байдаг юм.

Тэр гаргасан зардлын ангилал юмыг нь тооцож үзсэн юм уу? Үнэхээр үндэслэлтэй юм уу?

Эсвэл тэр болтол нь зарцуулах том эрхийг нь зүгээр нээгээд өгчхөж байгаа юм уу?

Сонгуулийн хууль чинь бас санхүүгийн хувьд нэлээн багасгах талын л юм барьсан шүү дээ. Уг нь бол.

Тэгээд наадах чинь иргэдийн хувьд маш тийм буруу ойлголт, буруу тоо оччихсон. Чи тэрбум хэдэн зуун төгрөгтэй учраас сонгуульд дэвших гээд байна гэдэг ийм ойлголт яваад байна шүү дээ.

Тэгээд би энэ дээр Сонгуулийн ерөнхий хорооноос тодруулга авъя гэж бодож байна. Асууж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Ер нь энэ талаар нэг тодорхой хариулт өгчих. Тийм ээ. Аудитаас хүн байхгүй байгаа билүү? Д.Бат-Эрдэнэ дарга хариулах уу? Тэгье.

Ер нь нэг тодорхой болчхож. Хүртэл гэсэн л агуулга нь шүү дээ. Тийм ээ. Гол нь.

Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгье.

Д.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу төрийн аудитын дээд байгууллагаас сонгуульд нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоодог.

Энэ бол дээд хэмжээ гэдгийг ойлгох хэрэгтэй.

Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр сонгуулийн зардлыг бууруулах дээр хоёр үе шаттай маш олон зохицуулалтууд орсон.

Энэ зардлын хэмжээ дунджаар 1.2 тэрбумаар төрийн аудитын дээд байгууллагаас тогтоогоод байгаа нь

сонгуулийн тойрог томорсонтой холбоотой.

Жишээлэх юм бол 2020 онд Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгууд тус тусдаа тойргууд байхад нэг аймагт нь дунджаар 400 орчим сая төгрөгийн зардлын дээд хэмжээ тогтоогдсон байна.

Энэ удаагийн сонгуулиар болохоор энэ 3 аймаг маань нийлээд нэг тойрог болж байгаа.

Тэгэхээр энэ дүнгээр нь харьцуулж үзэх юм бол 2020 онд нэг аймагт зарцуулах зардлын дүнгээсээ хэтрээгүй байгаа.

2020 онд байсан дүн 2024 онд байсан дүнтэйгээ нэг хэмжээнд байгаа нь сонгуулийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн зохицуулалтын үр дагаврууд гарч байна. Зардлын хэмжээг тодорхой бууруулах зохицуулалтууд хэрэгжиж эхэлсэн гэж хэлэх боломжтой гэж үзэж байгаа. Нийлчихсэн учраас.

Л.Мөнхбаатар: Ц.Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Тийм. Нэгдүгээрт яах вэ, “хүртэл” гэдгээ нэг зөв ойлгуулах хэрэгтэй байх. Яг сонгуулийн байгууллагаас. Нэгдүгээрт, тэр.

Хоёрдугаарт, та сая урьд нь гарсан дүнг тойрог нь томсоод тэдээр нь үржүүлээд гаргаад хэлчихсэн юм шиг юм ярьж байна шүү дээ.

Тэр урьд нь гарсан дүн нь юун дээр суурилж гарсан юм бэ? Урьд нь гарсан дүнгийн чинь гол зардал гаргадаг юмыг нь 50 хувиар багасгаж өгсөн

байхгүй юу. Энэ хууль. Одоо бидний мөрдөж байгаа одоогийн хууль.

Тэгэхээр энэ дээр Сонгуулийн ерөнхий хороо үнэхээр тэр тэрбум 200, 300 гээд байгаа тэр дүн үнэхээр бодитой юм уу, үгүй юм уу гэдгийг нь бас нэг хянаж үзээд энэ иргэд олон нийтэд сонгуулийн өмнө нэг тайлбарлаж өгөөсэй.

Магадгүй энэ чинь хуулийг нь өөрчилж болохгүй болохоос биш гарах зардлыг өөрчилж болохгүй гэсэн юм байхгүй шүү дээ. Дээд хязгаарыг.

Би хуулийн янз янзын тийм хориг байхгүй болов уу гэж ингэж бодож байгаа юм.

Тэгэхээр нөгөө үндсэн сонгуулийн зардлыг багасгана гэсэн тэр зарчмаа таны тайлбараас.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ дарга хариулья.

Д.Бат-Эрдэнэ: Сонгуулийн зардлыг бүрдүүлж байгаа үндсэн хэлбэр энэ сурталчилгаа явуулж байгаа 8 арга хэлбэр байгаа.

Тэгээд 8 арга хэлбэр бүгд тоотой, хэмжээтэй. Энэ тоо хэмжээг 50 хүртэл хувиар бууруулж өгсөн.

Ийм ч үүднээсээ 2020 онд жишээлэх юм бол нэг хэсэг дээр хоёр тээврийн хэрэгсэл явна гээд шатахууны зардлыг тооцдог байсан бол одоо 2024 онд 2020 оны хэмжээтэйгээ байж байгаа нь энэ эрх зүйн зохицуулалтын үр нөлөө гарч байна гэж үзнэ.

Нөгөө талаараа Сонгуулийн ерөнхий хорооноос бас энэ асуудлаар төрийн аудитын эрх бүхий байгууллагатай нь буюу тодорхой уулзалт хийгээд зардлын дээд хэмжээ тогтоосон аргачлал буюу энэ яаж тогтоосон зах зээлийн ханшийн талаар тодорхой мэдээллүүдийг авсан.

Ер нь эрх зүйн зохицуулалтын бууруулах энэ зохицуулалтыг хийгээгүй байсан бол магадгүй үүнээс өндөр дүн гарах ийм боломжтой байсан юм билээ л гэдэг тайлбарыг өгч байна лээ.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хурааа.

Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явагдана.

Санал саналын томьёололыг уншиж танилцуулсан байгаа. Гишүүд орж ирье.

Санал хураалт. /алх цохив/

51.3 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн

байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийнхаа асуудалд орёе.

**Ес.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/**

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна.

Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулаарай.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16, 17-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, санал гаргаагүй болно.

Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16, 17-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасныг баримтлан зарчмын зөрүүтэй 11 саналаар санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүл

мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Д.Сарангэрэл гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Пүрэвийн Оюунцэцэг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Намдагийн Гэрэлт-Од, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Ганхуягийн Түвшинбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын

даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Шаравнямбуугийн Энхтуяа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Лхамжавын Зэндмаа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Даваасүрэнгийн Оюун-Эрдэнэ, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Тогтохын Мөнхтуул, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Рэнцэнгийн Энхсүрэн, “Эрүүл мэнд реформ” төрийн бус байгууллагын гишүүн Машбаатарын Халиунаа, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн Мятавын Бат-Эрдэнэ нар оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Нөгөө маргаантай асуудлуудаа Байнгын хороон дээрээ нэгтгэсэн гэж ойлголоо. Тийм ээ.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 11 санал байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын танилцуулъя.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал байна.

1.Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийн “олгох,” гэсний дараа “сунгах, түдгэлзүүлэх, сэргээх,” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “нөлөөт эм” гэсний дараа “, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.2 дахь заалтын “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл гэсэн төрлөөр” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн бүрэлдэхүүн” гэж өөрчилж, 6.1.1 дэх заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 6.1.2 дахь заалтын “уламжлалт эм/” гэснийг, мөн зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

Нямаагийн Энхболд гишүүн горимын санал гаргая.

Н.Энхболд: Минийх уг нь дэмжээд яасан ч эсрэг гарчхаад. Саналаа хүчингүй болгоод дахиж санал хурааж өгч явуулна уу? Тийм.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдын гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт хүчингүйд тооцлоо.

Үндсэн санал хураалтын томъёололыг уншиж танилцуулсан байгаа.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хамт тухайн” гэснийг “хуулийн этгээд” гэж, мөн хэсгийн “нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгоно” гэснийг “нийлүүлж болно” гэж, 7.2.1, 7.2.2 дахь заалтын “сан бүхий энэ хуулийн 6.1.3-т заасан худалдах” гэснийг “сангийн” гэж, мөн заалтын “дүүргийн эмийн сангүй” гэснийг “сангийн хүрэлцээгүй” гэж, 7.2 дахь хэсгийн, 7.5.1, 7.5.2, 7.5.3, 7.5.4 дэх заалтын “олгох, сунгахад” гэснийг “олгоход” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3.1-д,” гэснийг, 7.13 дахь хэсгийн “хууль эрх зүйн хүрээнд” гэснийг тус тус хасаж, 7.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүнээ” гэсний дараа “түүхий эдээ” гэж, 7.11 дэх хэсгийн “саналаар” гэсний дараа “хуралдааны шийдвэр” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.16 дахь хэсэг нэмэх:

“7.16.Энэ хуулийн 7.5.1, 7.5.3, 7.5.4, 19.1, 29.2.4-т заасан зохистой дадлын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.”

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.1.Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн хүсэлт, баримт бичиг, түүнд хийсэн шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн уг бүтээгдэхүүнийг бүртгэнэ.

41.6.Энэ хуулийн 41.1-д заасны дагуу бүртгэгдсэн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний жагсаалтыг цахим хуудсанд байршуулж, эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.”

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “энэ хуулийн 7.5-д заасан баримт бичгийг бүрдүүлж,” гэснийг хасаж, мөн хэсгийн “энэ хуулийн 8-11 дүгээр зүйлд заасан үүрэг, шаардлагыг биелүүлсэн байна” гэснийг “Эрүүл мэндийн тухай хуулийн 19.17-д заасныг үндэслэнэ” гэж өөрчилж, мөн зүйлийн 12.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 41 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 41.12 дахь хэсэг нэмэх:

“41.12.Энэ хуулийн 41.6-д заасны дагуу бүртгэгдсэн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг иргэн, хуулийн этгээд борлуулж болно.”

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.3, 46.9, 46.10 дахь хэсгийн “тусламж, төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 46.10.1 дэх заалтын “шаардлага” гэснийг “стандарт” гэж, 46.10.6 дахь заалтын “эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг” гэснийг “эмийг” гэж тус тус өөрчилж, 46.11 дэх хэсгийн “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг хасаж, мөн хэсгийн “46.10.6” гэсний дараа “46.10.7” гэж нэмж, 46.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.1.Тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авахад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, хандивын эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авахад эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус урьдчилан мэдэгдэнэ.”

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалтын “болон орон нутгийн”, “иргэнд үзүүлэх” гэснийг, 47.1.4 дэх заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 47.1.1 дэх заалтын “шаардлагатай” гэснийг “түгээмэл хэрэглэгддэг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн зарчмын зөрүүтэй саналын томьёололыг хэлэлцье.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал байна.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалтыг хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 13.17 дахь заалтын “нөлөөт эм,” гэсний дараа “, эмнэлгийн тоног

төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж нэмж, 13.18 дахь заалтын “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл гэсэн төрлөөр” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж өөрчилж, мөн заалтын 13.17 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 13.17, 13.19 дэх заалтын “гэсэн төрлөөр” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “12.1 дэх заалтын” гэсний дараах ““Эмийн” гэснийг “Эм, эмнэлгийн хэрэгслийн” гэж, мөн заалтын” гэж нэмэх.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/ Санал хураалт гишүүд ээ.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “13.6” гэсний дараа “, 13.7” гэж нэмэх.

Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын

байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалд орёе.

Арав.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан ийм хуулиуд байгаа юм.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг баримтлан Байнгын хорооноос боловсруулсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт

орлуулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хуулийн төслийг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нийцүүлэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөх зохицуулалтыг тусгаж боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гаргаагүй тул Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Д.Сарангэрэл гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Байнгын хороо Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн

анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая.

Санал хураалт. /алх цохив/

51.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

Дараагийн асуудал оръё.

Арав нэг.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан,
анхны хэлэлцүүлэг/

Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан төсөл байна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна.

Таныг индэрт.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг баримтлан Байнгын хорооноос боловсруулсан Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 05

дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хуулийн төслийг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нийцүүлэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөх зохицуулалтыг тусгаж боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хурал хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны

санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Л.Мөнхбаатар: Ц.Идэрбат гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Байнгын хороо Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

51.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлж байна. /алх цохив/

Хуралдаан 3 цаг 07 минут үргэлжилж, 17 цаг 37 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД